



НҮБ-ын Хүн Амын сан



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC

# СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВЛҮР  
ХАМГААЛАХ БАЙРААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН  
СЭТГЭЛ ХАНАМЖ БОЛОН ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ,  
ОЙЛГОЛТ, ХАНДЛАГЫГ ҮНЭЛЭХ



**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

**НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ/ТҮР ХАМГААЛАХ  
БАЙРААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ  
БОЛОН ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ,  
ХАНДЛАГЫГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР  
2020 ОН

Судалгааны тайлан хянасан:

А.Амарбал	ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга
Л.Зулцэцэг	Судалгааны ажилтан

Судалгааны тайлан боловсруулахад оролцсон:

Н.Должинсүрэн	ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын ахлах статистикч
Г.Уранбайгаль	Судалгааны ажилтан
Д.Ганчимэг	Судалгааны ажилтан
Г.Эрдэнэ	Судалгааны ажилтан

## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу  
Засгийн газрын III байр  
Утас: (+976) 11 326414  
Факс: (+976) 11 324518  
Цахим хуудас: [www.nso.mn](http://www.nso.mn)  
Цахим хаяг: [international@nso.mn](mailto:international@nso.mn)

Үндэсний Статистикийн Хорооноос эрхлэн гаргав.  
Улаанбаатар хот, Монгол Улс, 2020 он

## АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	8
<b>БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>	9
<b>БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ</b>	11
<b>БҮЛЭГ 3. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА</b>	18
3.А. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэгийн түвшин	18
3.В. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, хандлага, итгэл үнэмшил	27
<b>БҮЛЭГ 4. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ БОЛОН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛОН МЭДЭЭЛЭЛ</b>	43
<b>БҮЛЭГ 5. НЦҮТ, ТҮР ХАМГААЛАХ БАЙРААР ҮЙЛЧЛҮҮЛСЭН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ БОЛОН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨЖ БАЙСАН БАЙДАЛ</b>	48
5.А. Хүчирхийлэлд өртөж, НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн, нэмэлт асуулгад хариулсан иргэд	50
5.В. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамж	52
<b>БҮЛЭГ 6. НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ БОЛОН ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ</b>	72
<b>БҮЛЭГ 7. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨГӨӨ</b>	82
<b>ХАВСРАЛТ 1 – СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НЭР</b>	88
<b>ХАВСРАЛТ 2 – АСУУЛГЫН ХУУДАС 1</b>	89
– АСУУЛГЫН ХУУДАС 2	





## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.	Судалгаанд хамрагдсан иргэд, хүйс, байршлаар, хувиар .....	11
Зураг 2.2.	Судалгаанд хамрагдсан иргэд, насны бүлгээр, хувиар .....	11
Зураг 2.3.	Судалгаанд хамрагдсан иргэд, насны бүлэг, хүйсээр, хувиар .....	12
Зураг 2.4.	Судалгаанд хамрагдсан иргэд, боловсролын түвшнээр, хувиар .....	13
Зураг 2.5.	Судалгаанд хамрагдсан иргэд, боловсролын түвшин, хүйсээр, хувиар .....	13
Зураг 2.6.	Хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар .....	14
Зураг 2.7.	Хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүйсээр, хувиар .....	14
Зураг 2.8.	Хөдөлмөр эрхлэхгүй байгаа иргэд, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар .....	15
Зураг 2.9.	Хөдөлмөр эрхлэхгүй, ажил хайхгүй байгаа иргэд, насны бүлгээр, хувиар .....	15
Зураг 2.10.	Ажил хайсан иргэд, ажил хайсан хэлбэрээр, хувиар .....	16
Зураг 2.11.	Ажил хайсан иргэд, насны бүлэг, ажил хайсан хэлбэрээр, хувиар .....	17
Зураг 3.1.	ЖСХ, ГБХ-ийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, хандлагын үнэлгээ (иргэд өөрийгөө үнэлсэн), хувиар .....	18
Зураг 3.2.	ЖСХ, ГБХ-ийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, хандлагын үнэлгээ (иргэд өөрийгөө үнэлсэн), хүйсээр .....	19
Зураг 3.3.	ЖСХ, ГБХ-ийн суурь шалтгааны талаарх иргэдийн ойлголт, хүйс, насны бүлгээр, хувиар .....	19
Зураг 3.4.	ЖСХ, ГБХ-ийн суурь шалтгаан, хувиар .....	20
Зураг 3.5.	ЖСХ, ГБХ нь хүний эрхийн зөрчил, гэмт хэрэг мөн эсэх иргэдийн ойлголт, хувиар .....	22
Зураг 3.6.	ЖСХ, ГБХ нь гэмт хэрэг болон хүний эрхийн зөрчил мөн эсэх талаарх иргэдийн ойлголт, хүйсээр, хувиар .....	22
Зураг 3.7.	ЖСХ, ГБХ нь хүний эрхийн зөрчил биш/мэдэхгүй гэж үзсэн иргэд насны бүлгээр, хувиар .....	23
Зураг 3.8.	ЖСХ, ГБХ нь гэмт хэрэг биш/мэдэхгүй гэж үзсэн иргэд насны бүлгээр, хувиар .....	23
Зураг 3.9.	ЖСХ болон ГБХ-ийн хохирогч хэн байх талаарх иргэдийн бодол, хувиар .....	24
Зураг 3.10.	ЖСХ, ГБХ үйлдэгч хэн байх талаарх иргэдийн бодол, хувиар .....	25
Зураг 3.11.	ЖСХ, ГБХ-ээс урьдчилан сэргийлэх арга зам, хувиар .....	27
Зураг 3.12.	ЖСХ, ГБХ-ийн гол буруутан нь эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй санал нийлсэн байдал, хүйсээр .....	28
Зураг 3.13.	ЖСХ, ГБХ-ийн гол буруутан нь эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр .....	29

Зураг 3.14.	ЖСХ, ГБХ-ийн гол буруутан нь эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр .....	30
Зураг 3.15.	ЖСХ, ГБХ-ийн гол буруутан нь эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй санал нийлсэн байдал, хүйс, насны бүлгээр, хувиар .....	31
Зураг 3.16.	Сайн эхнэр санал нийлэхгүй байсан ч нөхрийнхөө саналыг дэмжих ёстой гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр, хувиар .....	32
Зураг 3.17.	Сайн эхнэр санал нийлэхгүй байсан ч нөхрийнхөө саналыг дэмжих ёстой гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр, хувиар .....	33
Зураг 3.18.	Сайн эхнэр санал нийлэхгүй байсан ч нөхрийнхөө саналыг дэмжих ёстой гэдэгтэй санал нийлсэн байдал, боловсролын түвшнээр, хувиар .....	33
Зураг 3.19.	Эхнэр буруу зүйл хийсэн байвал нөхөр нь зодож, зэмлэж, шийтгэж болно гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр, хувиар .....	34
Зураг 3.20.	Эхнэр буруу зүйл хийсэн байвал нөхөр нь зодож, зэмлэж, шийтгэж болно гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр, хувиар .....	35
Зураг 3.21.	Хүчирхийллийг зөвтгөх үндэслэл байж болно гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр, хувиар .....	36
Зураг 3.22.	Хүчирхийллийг зөвтгөх үндэслэл байж болно гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр, хувиар .....	36
Зураг 3.23.	Хүчирхийллийг тэвчсэнээр гэр бүлээ аварч, хүүхдүүдээ өнчрүүлэхгүй гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр, хувиар .....	37
Зураг 3.24.	Хүчирхийллийг тэвчсэнээр гэр бүлээ аварч, хүүхдүүдээ өнчрүүлэхгүй гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр, хувиар .....	38
Зураг 3.25.	Хүчирхийллийг тэвчсэнээр гэр бүлээ аварч, хүүхдүүдээ өнчрүүлэхгүй гэдэгтэй санал нийлсэн байдал, боловсролын түвшнээр, хувиар .....	39
Зураг 3.26.	Судалгаанд хамрагдсан иргэдийн ирээдүйд итгэх итгэл, хувиар ....	40
Зураг 3.27.	Өрхийн наад захын хэрэгцээгээ хангадаг байдал, хүйс, байршлаар, хувиар .....	40
Зураг 3.28.	Өрхийн наад захын хэрэгцээгээ хангадаг байдал, боловсролын түвшнээр, хувиар .....	41
Зураг 3.29.	Ирэх жилүүдэд амьдрал улам сайхан болно гэдэгтэй санал нийлсэн байдал, хүйс, байршлаар, хувиар .....	42
Зураг 4.1.	Хүний эрхийн комисст гомдол гаргаж байсан байдал, хувиар .....	43
Зураг 4.2.	Хамтарсан баг, ТББ-ын зохион байгуулсан олон нийтийн болон дэмжих бүлгийн талаарх иргэдийн мэдлэг, хувиар .....	44
Зураг 4.3.	“Ойлгоё, хүндэлье” аяны уриа, зураг .....	45

Зураг 4.4.	“Ойлгоё, хүндэлье” уриаг харсан байдал, хувиар .....	46
Зураг 4.5.	“Ойлгоё, хүндэлье” уриаг харсан байдал, байршлаар, хувиар .....	46
Зураг 5.1.	ЖСХ болон ГБХ-д өртөж байсан эсэх, байршил, хүйсээр, хувиар .....	48
Зураг 5.2.	ЖСХ болон ГБХ-д өртөж байсан эсэх, насны бүлгээр, хувиар .....	49
Зураг 5.3.	Оршин суугаа аймаг/дүүрэгт нь НЦҮТ болон ТХБ байдаг талаарх мэдээлэлтэй иргэд, хувиар .....	50
Зураг 5.4.	Нэмэлт асуулгад сонгогдсон иргэд болон хариулахыг зөвшөөрсөн байдал, хувиар .....	50
Зураг 5.5.	Нэмэлт асуулгад хариулахыг зөвшөөрсөн эсэх, хүйс, байршлаар, хувиар .....	51
Зураг 5.6.	Нэмэлт асуулгад хариулахыг зөвшөөрсөн эсэх, насны бүлгээр, хувиар .....	52
Зураг 5.7.	НЦҮТ болон ТХБ-ны талаарх мэдээллийг авсан эх сурвалж, хувиар .....	53
Зураг 5.8.	НЦҮТ болон ТХБ-ны талаарх мэдээллийг авсан эх сурвалж, байршлаар, хувиар .....	54
Зураг 5.9.	НЦҮТ болон ТХБ-ны талаарх мэдээллийг авсан эх сурвалж, хүйсээр, хувиар .....	54
Зураг 5.10.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, үйлчлүүлсэн давтамжаар .....	55
Зураг 5.11.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, хүйс, байршил, давтамжаар, хувиар .....	56
Зураг 5.12.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, насны бүлэг, давтамжаар, хувиар .....	57
Зураг 5.13.	НЦҮТ болон ТХБ-нд ирсэн нөхцөл, байдал, хувиар .....	57
Зураг 5.14.	НЦҮТ болон ТХБ-нд ирсэн нөхцөл, байдал, хүйс, байршлаар, хувиар .....	58
Зураг 5.15.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн зорилго, хувиар .....	59
Зураг 5.16.	НЦҮТ болон ТХБ-нд ирсэн зорилго, хүйс, байршлаар, хувиар .....	59
Зураг 5.17.	НЦҮТ болон ТХБ-нд ирсэн зорилго, насны бүлгээр, хувиар .....	60
Зураг 5.18.	НЦҮТ болон ТХБ-нд ирээд авсан үйлчилгээ, хувиар .....	60
Зураг 5.19.	НЦҮТ болон ТХБ-нд ирээд үйлчилгээ авсан иргэд, хүйс, байршлаар, хувиар .....	60
Зураг 5.20.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд үйлчилгээгээ бүрэн авсан байдал, хүйс, байршлаар, хувиар .....	62
Зураг 5.21.	НЦҮТ болон ТХБ-нд ирээд хүссэн үйлчилгээгээ авсан байдал, хувиар .....	62
Зураг 5.22.	НЦҮТ болон ТХБ-нд ирээд хүссэн үйлчилгээгээ авсан байдал, хүйс, байршлаар, хувиар .....	63
Зураг 5.23.	НЦҮТ болон ТХБ-нд ирээд хүссэн үйлчилгээгээ авсан байдал, насны бүлгээр, хувиар .....	64
Зураг 5.24.	Үйлчилгээ үзүүлэгчдийн хандлага, харилцаанд өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар .....	65

Зураг 5.25.	Үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг, туршлагад өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар .....	65
Зураг 5.26.	Үйлчилгээний чанарт өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар .....	65
Зураг 5.27.	Байрны тохижилтод өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар .....	66
Зураг 5.28.	Нууцлал, аюулгүй байдалд өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар .....	66
Зураг 5.29.	Үйлчилгээ үзүүлэгчдийн хандлага, харилцаанд өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар .....	67
Зураг 5.30.	Үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг, туршлагад өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар .....	67
Зураг 5.31.	Үйлчилгээний чанарт өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар .....	68
Зураг 5.32.	Байрны тохижилтод өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар .....	68
Зураг 5.33.	Нууцлал, аюулгүй байдалд өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар .....	68
Зураг 5.34.	НЦҮТ болон ТХБ-ны давуу болон сул талыг үнэлсэн байдал, хүйс, байршлаар, хувиар .....	69
Зураг 5.35.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлснээр гарсан өөрчлөлт, хүйс, байршлаар, хувиар .....	70
Зураг 5.36.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлснээр гарсан өөрчлөлт, насны бүлгээр, хувиар .....	71
Зураг 6.1.	НЦҮТ болон ТХБ-ны тоо, байгуулагдсан оноор .....	72
Зураг 6.2.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо, хүйсээр, 2014-2019 он .....	73
Зураг 6.3.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, аймаг, нийслэл, хүйсээр, хувиар, 2019 он .....	74
Зураг 6.4.	НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, аймаг, нийслэл, хүйсээр, хувиар, 2017-2018 он .....	74
Зураг 6.5.	НЦҮТ болон ТХБ-ны ажиллагчдын тоо болон давтамж .....	78

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 6.1.	НЦҮТ болон ТХБ-ны хэмжээ .....	75
Хүснэгт 6.2.	НЦҮТ болон ТХБ-ны хүчин чадал .....	76
Хүснэгт 6.3.	НЦҮТ болон ТХБ-ны тохижилтонд судлаачийн өгсөн үнэлгээ .....	78
Хүснэгт 6.4.	НЦҮТ болон ТХБ-ны үйлчилгээнд судлаачийн өгсөн үнэлгээ .....	79
Хүснэгт 6.5.	НЦҮТ болон ТХБ-нд хийх шаардлагатай үйл ажиллагаа .....	80

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БЗД	Баянзүрх дүүрэг
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХЗХХ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс
ГССҮТ	Гэмтэл, согог судлалын үндэсний төв
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЖСХС	Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
НҮБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан
СБД	Сүхбаатар дүүрэг
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТХБ	Түр хамгаалах байр
ХУД	Хан-Уул дүүрэг
ХАНСГ	Хүн ам, нийгмийн статистикийн газар
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн

## БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ) болон Түр хамгаалах байр (ТХБ)-аар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн байдлын үнэлгээ, Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-ийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгааг 21 аймаг, Улаанбаатар хотын 6 дүүргийн хэмжээнд 2019 онд зохион байгуулан явууллаа.

Судалгааг Швейцарийн хөгжлийн агентлагын санхүүжилтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын сан, Монгол Улсын засгийн газрын хамтран хэрэгжүүлж байгаа Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь төслийн хүрээнд Үндэсний статистикийн хороо зохион байгуулж, мэдээллийг цуглуулан, нэгдсэн үр дүнг тооцон гаргаад байна.

### Судалгааны зорилго:

ЖСХ болон Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ)-ийн талаарх иргэдийн мэдлэг, ойлголт, хандлагыг судлах, НЦҮТ болон ТХБ-ны нөхцөл байдал, хүчин чадлыг үнэлэх, түүнчлэн судалгаанд хамрагдагчид өөрийн амьдарч буй газартаа НЦҮТ, ТХБ байдаг эсэхийг мэддэг талаар, хэрэв эдгээр газраар үйлчлүүлсэн бол үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамж ямар түвшинд байгааг тодорхойлохыг зорилоо.

### Судалгааны зорилт:

- ЖСХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг судлах;
- Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээллийг олон нийт хаанаас, хэрхэн авдаг байдлыг судлах;
- НЦҮТ болон ТХБ-ны нөхцөл байдалд үнэлгээ хийх;
- НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн байдалд үнэлгээ хийх;

### Судалгааны төлөвлөлт:

Судалгааг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, 2019 оны 11 сард судалгааны маягт, зааврыг боловсруулах, судлаачдын сургалт явуулах зэрэг ажлыг зохион байгуулсан. Судалгааны асуулга нь 2 төрөлтэй бөгөөд дараах асуултуудаас бүрдсэн. Үүнд:

1. НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ БОЛОН ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АСУУЛГА (9 асуулттай):
  - a. Хаягийн хэсэг
  - b. Байгуулагдсан он
  - c. НЦҮТ/ТХБ-аар үйлчлүүлсэн хүний тоо

- d. Нийт ажиллагчдын тоо
  - e. Хүчин чадал
  - f. 2020 онд яаралтай хийх шаардлагатай тулгамдсан үйл ажиллагаа
  - g. Судлаачийн дүгнэлт
    - Тохижилтын хувьд
    - Үйлчилгээний хувьд
  - h. НЦҮТ/ТХБ-нд хийх нэн шаардлагатай үйл ажиллагаа
2. ЖСХ-ИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГ, ХАНДЛАГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ (49 асуулттай):
- a. Хаягийн хэсэг
  - b. Нийгэм, эдийн засгийн байдал
  - c. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, мэдлэг
  - d. НЦҮТ/ТХБ-ны талаарх мэдээлэл
  - e. НЦҮТ/ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн үнэлгээ
  - f. Ирээдүйн үнэлгээ
  - g. “Ойлгоё, хүндэлье” аяны талаарх мэдээлэл

#### **Судалгааны мэдээлэл цуглуулалт:**

Мэдээлэл цуглуулалтыг 2019 оны 12 сарын турш хийсэн бөгөөд 21 аймаг тус бүрээс 150-180 хүн, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргээс нийт 1600 орчим хүн хамрагдсан. Мөн НЦҮТ болон ТХБ-ны нөхцөл байдал, үйл ажиллагаанд судлаачид үнэлгээ хийж, эдгээр байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээс мэдээлэл цуглуулав.

Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд аймаг, дүүргийн Статистикийн хэлтсийн хамт олон дэмжлэг үзүүлэн оролцож, баг, хорооны удирдлагад мэдээлэл өгч, хамтран ажиллав.

#### **Судалгааны мэдээлэл боловсруулалт:**

Судалгааны анхдагч мэдээллийг шивж оруулах программыг (CSPro программ дээр) боловсруулж, холбогдох бүх мэдээллийг шивж оруулан нэгтгэсэн.

CSPro программ дээр нэгтгэсэн мэдээллийг SPSS программ руу хөрвүүлж, анхдагч мэдээллийн уялдаа, холбоог шалгах, үр дүнгийн хүснэгт боловсруулах, анализ, шинжилгээ зэргийг хийлээ.




## БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлыг тодорхойлох зорилгоор нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуултуудыг оруулж өгсөн.

Судалгаанд аймаг бүрээс 150-180 хүн, Улаанбаатар хотын дүүрэг тус бүрээс 200-300 хүнийг, нийт 5000 хүнийг хамруулсан бөгөөд эдгээр иргэдийн 26.2 хувь нь эрэгтэйчүүд, 73.8 хувь нь эмэгтэйчүүд байна.


Зураг 2.1. Судалгаанд хамрагдсан иргэд, хүйс, байршлаар, хувиар



Эдгээр иргэдийг байршлаар харахад 32.3 хувь нь нийслэлд, 57.0 хувь нь аймгийн төвд, 8.9 хувь нь сумын төвд, 1.8 хувь нь хөдөө амьдарч байна.

Харин насны бүлгээр авч үзвэл судалгаанд 25-34 насныхан хамгийн их хамрагдсан байна (Зураг 2.2).

Зураг 2.2. Судалгаанд хамрагдсан иргэд, насны бүлгээр, хувиар






Энэ насны хүмүүс нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 33.6 хувийг эзэлсэн бол 35-44 насныхан 22.7 хувийг, 15-24 насныхан 17.2 хувийг, 45-54 насныхан 15.9 хувийг эзэлж байна. Харин 55 наснаас дээш насныхан нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 10.6 хувийг эзэлж байна.

Иргэдийг насны бүлэг болон хүйсээр харахад 15-24, 75-86 насныхны дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдээсээ илүү байгаа бол бусад насны бүлэгт эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байна (Зураг 2.3).

Зураг 2.3. Судалгаанд хамрагдсан иргэд, насны бүлэг, хүйсээр, хувиар




Судалгаанд хамрагдсан нийт иргэдийг боловсролын түвшнээр нь харахад дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэд 41.9 хувь, бүрэн дунд боловсролтой иргэд 29.8 хувь байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна. Мөн суурь боловсролтой, техникийн болон мэргэжлийн боловсролтой, тусгай мэргэжлийн дунд боловсролтой иргэд 5.8-6.9 хувийг, боловсролгүй болон бага боловсролтой иргэд 2.0-3.1 хувийг эзэлж байна.

Зураг 2.4. Судалгаанд хамрагдсан иргэд, боловсролын түвшинээр, хувиар



Иргэдийн боловсрол эзэмшсэн байдлыг хүйсээр харахад илүү сонирхолтой дүр зураг харагдаж байна. Магистр/доктор, дипломын болон бакалаврын дээд боловсрол, тусгай мэргэжлийн дунд боловсрол эзэмшсэн иргэдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байгааг Зураг 2.5-аас харж болох юм.

Зураг 2.5. Судалгаанд хамрагдсан иргэд, боловсролын түвшин, хүйсээр, хувиар




Судалгаанд хамрагдсан иргэдийн 31.5 хувь нь ямар нэгэн хөдөлмөр эрхлэхгүй байгаа бол 68.5 хувь нь хөдөлмөр эрхэлж байна (Зураг 2.6). Ажил, хөдөлмөр эрхэлж буй эдгээр иргэдийн 81.7 хувь нь цалин, хөлстэй хөдөлмөр эрхэлж байгаа бол 11.3 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Харин газар тариалан эрхлэгч 0.2 хувь, цалин хөлсгүй буюу гэрийн ажил хийж буй хүн 1.3 хувь, мал аж ахуй эрхлэгч 2.5 хувийг эзэлж байгаа бол бусад төрлийн хөдөлмөр эрхэлж байна гэсэн хариултыг судалгаанд хамрагдсан иргэдийн 3.0 хувь нь өгчээ.

Зураг 2.6. Хөдөлмөр эрхлэлтийн байдал, хувиар




Түүнчлэн хөдөлмөр эрхэлж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг хүйсээр авч үзэхэд онцын ялгаа харагдахгүй байна.

Зураг 2.7. Хөдөлмөр эрхлэлтийн байдал, хүйсээр, хувиар



Харин хөдөлмөр эрхлээгүй нийт 1577 иргэн байгаа ба тэдний хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгааныг дараах зурагт харууллаа.


Зураг 2.8. Хөдөлмөр эрхлэхгүй байгаа иргэд, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар



Хөдөлмөр эрхлэхгүй байгаа шалтгаанд бусад гэсэн шалтгаан хамгийн их буюу 42.5 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр иргэдийн ихэнх нь тэтгэвэрт гарсан, өндөр настай иргэд болон мэргэжил эзэмшээгүй иргэд, оюутан, сурагчид байна.

Хөдөлмөр эрхлэхгүй байгаа иргэдээс сүүлийн 7 хоногт ажил хайсан байдлыг тодруулахад тэдний 86.4 хувь нь ажил хайгаагүй гэсэн хариулт өгчээ. Зөвхөн 13.6 хувь нь ажил хайсан байна.

Зураг 2.9. Хөдөлмөр эрхлэхгүй, ажил хайхгүй байгаа иргэд, насны бүлгээр, хувиар



Ажил хайгаагүй иргэдийг насны бүлгээр харахад 15-24 насныхан хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь эдгээр насны залуучууд сурч, боловсрол

эзэмшиж байгаатай холбоотой байна. Түүнчлэн 25-34 насныхан ажил хайхгүй байгаа нийт иргэдийн 22.2 хувийг эзэлж байгаа нь өндөр хувьтай байна.

Өмнө дурдсан ажил хайж байгаа иргэд ажил хайхдаа дараах аргуудыг хэрэглэсэн байна.


Зураг 2.10. Ажил хайсан иргэд, ажил хайсан хэлбэрээр, хувиар



Иргэд ажил хайхдаа найз, нөхөд, хамаатан саднаасаа тусламж хүсэх хэлбэрийг илүүтэй сонгодог байна (Зураг 2.10). Үүний дараа Хөдөлмөрийн хэлтэс, Хөдөлмөрийн биржид ханддаг болон хэвлэл, мэдээллийн зарын дагуу ажил хайсан хэлбэр өндөр хувьтай байна. Харин ажил олгогч нарт өргөдөл гаргаж хандсан тохиолдол нийт ажил хайгчдын 11.2 хувийг, өөрөө сонинд зарлал өгсөн тохиолдол 1.9 хувийг эзэлж байна.

Ажил хайсан иргэдийг ажил хайсан хэлбэр болон насны бүлгээр харахад 15-24 насныхан хэвлэл, мэдээллийн зарын дагуу ажил хайхыг илүүд үзэж байгаа бол 25-34 насныхан найз нөхөд, хамаатан саднаасаа тусламж хүсэх болон Хөдөлмөрийн хэлтэс/Хөдөлмөрийн биржид хандах аргыг түлхүү хэрэглэж байна (Зураг 2.11). Мөн 35-44 насныхны дунд найз нөхөд, хамаатан саднаасаа тусламж хүссэн тохиолдол хамгийн их буюу 44.1 хувь байна. Харин 45-54 насныхан хэвлэл, мэдээллийн зарын дагуу ажил их хайдаг бол 55-64 настай иргэд Хөдөлмөрийн хэлтэс/Хөдөлмөрийн биржид хандах болон бусад аргаар ажил хайдаг байна. Түүнчлэн зургаас харахад 75-аас дээш насныхан ч боломжийн, өөрт тохирсон ажил хайдаг байна.

Зураг 2.11. Ажил хайсан иргэд, насны бүлэг, ажил хайсан хэлбэрээр, хувиар



Ажил хайсан иргэдийн ажил хайхдаа хэрэглэсэн аргыг хүйсээр харахад онцын ялгаа ажиглагдсангүй.


## БҮЛЭГ 3. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА

Бид энэхүү судалгаагаар Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) гэж юу болох, энэ төрлийн хүчирхийллийн суурь шалтгаан, хүчирхийлэлд нөлөөлдөг хүчин зүйл юу болох талаар асуусан. Түүнчлэн ЖСХ болон ГБХ нь хүний эрхийн зөрчил болон гэмт хэрэг мөн эсэх талаар иргэдийн ойлголтыг судаллаа. ЖСХ болон ГБХ-ийн талаарх иргэдийн ойлголт, хандлага, мэдлэгийг судлах зорилгоор нийт 49 төрлийн асуултыг асуусан ба асуултын мэдээллийг нэгтгэн энэ бүлэгт танилцуулж байна.

### 3.А. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэгийн түвшин

“Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн талаар Та өөрийгөө хэр мэдлэгтэй гэж дүгнэх вэ?” гэсэн асуултад иргэд өөрсдийгөө 1-9 оноогоор үнэлсэн (Зураг 3.1). Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 2248 буюу 45.0 хувь нь ЖСХ болон ГБХ-ийн талаарх өөрсдийн мэдлэгийг дунд зэрэг буюу 5 оноогоор үнэлжээ.

Зураг 3.1. ЖСХ, ГБХ-ийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, хандлагын үнэлгээ (иргэд өөрийгөө үнэлсэн), хувиар



Зураг 3.1-ээс харахад иргэдийн 23.1 хувь нь ЖСХ болон ГБХ-ийн талаарх өөрсдийн мэдлэг, ойлголтыг “МУУ” байгаа буюу 1-4 оноогоор үнэлсэн байна. Харин 6-9 оноогоор буюу мэдлэг “САЙН” гэж 31.9 хувь нь үнэлжээ.


Дээрх үр дүнгээс харахад ЖСХ болон ГБХ-ийн талаарх иргэдийн мэдлэг,

ойлголт бага байгаа нь иргэдийн ихэнх нь (68.1 хувь) өөрсдийнхөө мэдлэгийг дунджаас доогуур гэж үнэлснээс харж болох юм.

Мөн энэ үзүүлэлтийг хүйсээр ялгаж харвал дараах байдалтай байна. Зургаас харахад ЖСХ болон ГБХ-ийн талаарх эрэгтэйчүүдийн мэдлэг, ойлголт эмэгтэйчүүдийнхээс доогуур байгаа нь харагдаж байна (Зураг 3.2).


ЖСХ болон ГБХ-ийн талаарх мэдлэгээ 1-4 гэж үнэлсэн эрэгтэйчүүдийн эзлэх хувь 27.7 байгаа бол эмэгтэйчүүд 21.5 хувьтай байна.

**Зураг 3.2. ЖСХ, ГБХ-ийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, хандлагын үнэлгээ (иргэд өөрийгөө үнэлсэн), хүйсээр**



Мөн түүнчлэн “ЖСХ болон ГБХ-ийн суурь шалтгаан юу вэ?” гэсэн асуултад нийт иргэдийн 824 буюу 16.5 хувь нь “ҮНЭХЭЭР МЭДЭХ ЮМ АЛГА” гэж хариулсан байна. Үлдсэн 83.5 хувь олон төрлийн шалтгааныг нэрлэсэн байна. Энэ үзүүлэлтийг хүйсээр харахад эрэгтэйчүүдийн 18.0 хувь, эмэгтэйчүүдийн 16.0 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

**Зураг 3.3. ЖСХ, ГБХ-ийн суурь шалтгааны талаарх иргэдийн ойлголт, хүйс, насны бүлгээр, хувиар**





ЖСХ болон ГБХ-ийн суурь шалтгааны талаарх иргэдийн ойлголтыг насны бүлгээр харахад 75-аас дээш насныхны дунд ЖСХ болон ГБХ-ийн суурь шалтгааны талаарх мэдлэг хамгийн их буюу 86.5 хувьтай байна. Үүний дараа 25-44 насныхны 84.2-84.7 хувь нь суурь шалтгааныг мэднэ гэжээ. Харин 55-64 насныхан хамгийн бага буюу 80.7 хувьтай байна.

Зураг 3.4-өөс харахад иргэдийн ихэнх буюу 40.0 орчим хувь нь ЖСХ болон ГБХ-ийн өдөөж буй гол хүчин зүйл бол архи, архидалт, мансуурч, согтуурах явдал гэдгийг дурдсан байна.

Зураг 3.4. ЖСХ, ГБХ-ийн суурь шалтгаан, хувиар



Мөн иргэдийн ихэнх нь хүмүүс хоорондын харилцаа, үйл ойлголцол, сэтгэл зүйн хүчин зүйлүүд тухайлбал, гэр бүлийн орчин, хүмүүжил, харилцаа, хандлага (13.8 хувь), харилцаа, үл ойлголцох байдал (10.9 хувь), хардалт, хадмын өдөөн хатгалт (7.4 хувь) нөлөөлж байна гэж үзжээ. Харин судалгаанд оролцогчдын цөөн хувь нь ажилгүйдэл (5.9 хувь), боловсрол муу байгаагаас (2.6 хувь), ядуурал, амьдралын түвшин доогуур байдал (1.1 хувь) зэрэг нийгмийн хүчин зүйлийг тодорхойлж хэлсэн байна.

Судалгаанд оролцогчдоос “ЖСХ, ГБХ-ийн суурь шалтгаан юу вэ?” гэж асуухад тодорхой зөв хариултыг өгч чадаагүй байна. Гэсэн хэдий ч зарим оролцогчид тэнцвэргүй байдал, жендэрийн тэгш бус байдал (3.0 хувь), уламжлалт ёс заншил, итгэл үнэмшил (1.0 хувь) гэж зөв хариулт өгсөн байна.

Оролцогчдын нэрлэсэн бусад хариултауд нь гол шалтгаан биш боловч ЖСХ, ГБХ-д нөлөөлдөг хүчин зүйлүүд байна. Энэ нь ЖСХ, ГБХ-ийн талаарх иргэдийн өөрсдийн мэдлэгийг нэлээд сайн гэж үнэлсэн (31.9 хувь) үнэлгээ болон энэ асуултад хариулсан байдал зэрэг нь иргэд тодорхой мэдлэггүйн дээр тэдний мэдлэгийн бодит зөрүүг илтгэж байна.

ЖСХ, ГБХ-ийн суурь шалтгаан нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох эрх мэдэл, хүчний ялгаатай байдал гэдгийг олон нийт тэр бүр мэддэггүй, зөвхөн хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлдөг хүчин зүйлүүдийг нэрлэсээр байна. Эндээс дүгнэж хэлэхэд ЖСХ-ийн талаарх иргэдийн мэдлэг хангалтгүй байна.

Хүчирхийллийн суурь шалтгааныг буруу ойлгох нь хүчирхийллийг зөвтгөх нөхцлийг бүрдүүлдэг. Тухайлбал, хүчирхийллийн суурь шалтгааныг архи, согтууруулах ундаа гэж ойлгосноос үүдэн хүчирхийллийг архи ууснаас болж үйлдсэн гэж тайлбарласнаар хүчирхийлэл үйлдсэн жинхэнэ суурь шалтгаан буюу эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын эрх мэдэл, хүчний ялгаатай байдал нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хооронд тэгш бус байдлыг үүсгэн, ингэснээр хүч, эрх мэдлээр дооргуур болон өөрийн эрхшээлд байгаа хэн нэгний эсрэг хүчирхийлэл үйлдэж байгаа мөн чанарыг үгүйсгэхэд хүргэж байна.

Судалгаанд хамрагдсан иргэдээс ЖСХ болон ГБХ нь гэмт хэрэг мөн эсэх, хүний эрхийн зөрчил мөн эсэх, түүнчлэн хүний эрхийн үндэсний комисст гомдол гаргаж байсан зэргийг тодруулсан. Ингэхэд ЖСХ болон ГБХ нь хүний эрхийн зөрчил мөн гэдэгтэй нийт иргэдийн 92.1 хувь нь, харин гэмт хэрэг мөн гэдэгтэй 88.8 хувь нь санал нийлсэн байна.


ЖСХ болон ГБХ-ийг хүний эрхийн зөрчил “Биш” эсвэл “Сайн мэдэхгүй байна” гэж нийт иргэдийн 392 буюу 7.9 хувь, гэмт хэрэг “Биш” эсвэл “Сайн мэдэхгүй байна” 560 буюу 11.2 хувь нь үзсэн байна. Харин ЖСХ, ГБХ нь зөрчил биш гэж иргэдийн 1.0 хувь нь, гэмт хэрэг биш гэж 2.8 хувь нь үзжээ. Түүнчлэн нийт иргэдийн 6.9 болон 8.4 хувь нь сайн мэдэхгүй байна гэж хариулжээ. Энэхүү ялгаатай байдал нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн талаар олон нийтэд мэдээлэх, сурталчлах, ЖСХ болон ГБХ үйлдэх гэмт хэргийн мөн чанар, үр дагаварын талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэж ажиллах хэрэгтэй байгааг харуулж байна.

Зураг 3.5. ЖСХ, ГБХ нь хүний эрхийн зөрчил, гэмт хэрэг мөн эсэх иргэдийн ойлголт, хувиар

ЖСХ болон ГБХ нь хүний эрхийн зөрчил мөн үү?




ЖСХ болон ГБХ нь гэмт хэрэг мөн үү?



Харин ЖСХ, ГБХ нь хүний эрхийн зөрчил, гэмт хэрэг мөн эсвэл биш гэж үзэж буй иргэдийг хүйсээр ялган харахад ЖСХ, ГБХ-ийг гэмт хэрэг биш, хүний эрхийн зөрчил биш гэж үзсэн эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс их байна.

Тухайлбал, ЖСХ, ГБХ-ийг гэмт хэрэг биш гэж эрэгтэйчүүдийн 4.0 хувь үзэж байгаа бөгөөд ийм бодолтой эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.6 пунктээр их байна. Мөн ЖСХ болон ГБХ нь хүний эрхийн зөрчил биш гэж эрэгтэйчүүдийн 1.1 хувь нь үзэж байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүдийн эзлэх хувиас 0.2 пунктээр их байна (Зураг 3.6).


Зураг 3.6. ЖСХ, ГБХ нь гэмт хэрэг болон хүний эрхийн зөрчил мөн эсэх талаарх иргэдийн ойлголт, хүйсээр, хувиар




Хүний эрхийн зөрчил биш болон мэдэхгүй байна гэж хариулсан иргэдийг насны бүлгээр харахад 25-34 насныхан хамгийн их буюу 32.0-35.4 хувийг эзэлж

байна. Гэсэн хэдий ч энэ насныхан нийт судалгаанд хамрагдагчдын 33.6 хувийг эзэлж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Мөн сонирхол татаж байгаа зүйл нь “Сайн мэдэхгүй байна” гэж хариулт өгсөн 15-24 насныхан (18.0-20.8 хувь) өндөр хувийг эзэлж байна, мөн 35-44 (18.8-22.4 хувь) насныхан өндөр хувийг эзэлж байна. Эндээс харахад мэдээлэл түгээх, мэдлэг олгох ажилд залуучуудыг түлхүү хамруулах нь чухал байгааг онцолмоор байна.

Зураг 3.7. ЖСХ, ГБХ нь хүний эрхийн зөрчил биш/мэдэхгүй гэж үзсэн иргэд насны бүлгээр, хувиар




Зураг 3.8. ЖСХ, ГБХ нь гэмт хэрэг биш/мэдэхгүй гэж үзсэн иргэд насны бүлгээр, хувиар



Мөн гэмт хэрэг биш гэж үзсэн иргэдийн хувьд мөн л 25-34 насныхан хамгийн их буюу 30.5-34.4 хувийг эзэлж байна. Гэсэн хэдий ч, 15-24 насны ЖСХ болон

ГБХ-ийн хохирогч нь хэн ч байж болох талаарх олон улсын судалгаагаар ГБХ-ийн 98.0 хувь нь эмэгтэйчүүд байдаг тул хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр олон төрлийн ажил хийгдсээр байна. Бид судалгаагаараа ЖСХ, ГБХ-ийн хохирогч хэн байж болох талаар судалсан бөгөөд энэхүү асуултын хариулт нь олон сонголттой байсан. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 54.6 хувь нь ЖСХ болон ГБХ-ийн хохирогч нь хүүхэд гэж хариулсан байна. Үүний дараа хүчирхийлэл үйлдэгчээс бусад бүх гишүүд гэж 54.4 хувь нь үзжээ. Эндээс харахад ЖСХ, ГБХ-ийн гол хохирогч нь хүүхэд болох нь харагдаж байна. Иймээс энэ талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг зөв болгох, ЖСХ болон ГБХ-ийг бууруулах, таслах зогсооход анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлага тулгараад байна.


Зураг 3.9. ЖСХ болон ГБХ-ийн хохирогч хэн байх талаарх иргэдийн бодол, хувиар



Дээрх зургаас харахад оролцогчдын 35.1 хувь нь эмэгтэйчүүд хохирогч болдог гэсэн бол 12.9 хувь нь ээж, аав, 10.5 хувь нь эрэгтэйчүүд гэж хариулжээ. Эндээс харахад ГБХ-ийн хохирогч хэн ч байж болох бөгөөд хүчирхийлэл үйлдэгч ч өөрөө хохирогч болж байдаг. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон өндөр настнууд хохирогч болох явдал нэлээдгүй байсаар байна.

ЖСХ болон ГБХ үйлдэгч хэн байж болох талаар иргэдээс асуухад нийт иргэдийн 37.5 хувь нь “хүчирхийлэгч хэн ч байж болно” гэсэн байна. Мөн айл гэрийн тэргүүн, нөхөр/зөвхөн эрэгтэйчүүд гэж 32.4 хувь нь, эхнэр буюу зөвхөн эмэгтэйчүүд гэж 7.1 хувь нь хариулжээ (Зураг 3.10). Мөн 6.2 хувь нь аав, 3.1 хувь нь ээж гэсэн байна. Эндээс харахад иргэдийн ихэнх нь хүчирхийлэл үйлдэгч нь эрэгтэйчүүд байдаг гэж үзсэн байна.

Зураг 3.10. ЖСХ, ГБХ үйлдэгч хэн байх талаарх иргэдийн бодол, хувиар



Түүнчлэн ах, дүү (1.6%), эгч (0.2%), хойд аав, ээж (1.5%), архи уусан хэн бүхэн (3.3%) найз, нөхөд (0.9%), өөрийн хүүхдүүд (0.9%), биеэ барих чадваргүй, боловсролгүй, буруу зуршилтай хүмүүс (0.9%), байгууллагын дарга, удирдлага (0.8%), сэтгэцийн өвчтэй хүн (0.4%), мөнгөтэй, эрх мэдэл бүхий хүн (0.3%), ажил олгогч (0.4%), хамаатан садан (0.2%) хүчирхийлэл үйлдэж байна гэж хариулсан байна.

Мөн өөрөө хүчирхийлэлд өртөж байсан хүн хүчирхийлэл үйлддэг гэж иргэдийн 0.4 хувь нь хариулжээ. Энэ нь хүчирхийлэгч хүчирхийлэгчийг төрүүлдэг гэдэг үгтэй утга нэг бөгөөд ЖСХС-ны мэдээлэл энэхүү үгийг мөн баталсан юм. Тухайлбал, судалгааны үр дүнгээр хүчирхийлэлтэй орчинд амьдарч

буй хүүхэд хүчирхийлэлгүй гэр бүлд амьдарч буй хүүхдээс илүү аймхай, түрэмгий ааштай, сурлага муутай байдаг зэрэг үр дүн гарсан. Түүнчлэн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн аав нь ээжийг нь зоддог байсан, хүчирхийлэгч өөрөө багадаа гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан зэрэг үр дүнг харж болох юм.

ЖСХ болон ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ямар арга зам байгааг асуухад оролцогчид ихэвчлэн сургалт, сурталчилгаа хийх, телевиз болон интернэтээр сурталчлах, сургууль, ажлын байранд сургалт хийх, хуулиа сурталчлах, хуулийн талаарх мэдлэгийг иргэдэд өгөх гээд маш олон төрлийн хариултыг өгсөн байна (Зураг 3.11).


Оролцогчдын саналыг дараах зургаас харж болох бөгөөд зөвлөгөө өгөх, сурталчилгаа, нөлөөллийн ажил хийх, мэдээлэл өгөх (ТВ гм), хууль сурталчлах нь чухал байна гэсэн хариултыг нийт иргэдийн 32.5 хувь нь өгсөн байна. Эндээс харахад иргэд сүүлийн үед мэдээлэл маш их авч байгаа гэсэн боловч иргэдийн зарим хэсэгт мэдээлэл огт хүрэхгүй, мэдлэг, мэдээлэл муутай, боловсрол багатай, өөрийгөө хамгаалах, хаана хандахаа мэдэхгүй хүмүүс нэлээд хувийг эзэлж байгаа нь мэдлэггүй, өөрийн мэдлэгт эргэлзэж байгааг харуулж байна. Энэ нь ЖСХ болон ГБХ-ийн талаарх мэдлэг хангалтгүй байна гэж олон нийт үзэж байгаа нь судалгаанд хамрагдсан иргэдийн 68.1 хувь нь өөрийн мэдлэгийг дундаас доогуур үнэлсэнээс харагдаж байна. Тиймээс энэ асуултад оролцогчдын 20.7 хувь нь хариулаагүй байхад, 4.6 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Түүнчлэн харилцан ярилцаж ойлголцох, бие биенээ хүндлэх, бие биенээ хайрлах хэрэгтэй гэж иргэдийн 10.0 хувь нь хариулжээ. Мөн архидалтыг бууруулах, архи, мансууруулах бодис хэрэглэхгүй байх, муу зуршлаасаа салах гэж 9.0 хувь нь, ажлын байр бий болгох, ард иргэдээ ажилтай-орлоготой болгох, ажилгүйдлийг бууруулах гэж 6.1 хувь нь хариулсан байна.

Хүүхдээ багаас нь зөв хүмүүжүүлэх, гэр бүлийн таатай орчинг бүрдүүлэх, зөв ёс суртахуунтай байлгах, гэр бүлээ зөв төлөвлөж сурах, муу, буруу хандлагыг арилгах, өөрчлөх, ядуурлыг бууруулах, амьжиргааны түвшинг сайжруулах, сэтгэл зүйчдийг маш сайн бэлтгэх, сэтгэл зүйн зөвлөгөөг маш өргөн хүрээнд өгдөг байх, хүүхэд, эмэгтэйчүүдийг хамгаалах, энэ чиглэлээр ажилладаг байгууллагууд ажлаа сайжруулах, хоорондоо уялдаатай ажиллах, хөршийн холбоог сайжруулах, тухай бүр цагдаад мэдэгдэж байх, 102 болон 108 дугаарт залгаж мэдээлэл өгдөг байх, баар, цэнгээний газрыг цөөрүүлэх, бусдын буруу үгийг дагаж, буруу үйл үйлдэхгүй байх зэрэг маш олон төрлийн хариултыг өгчээ.

Сургуулийн хөтөлбөрт оруулах болон сургууль дээр нь сургалт маш сайн хийх, ажлын байранд ёс зүйн хичээл, сургалт явуулах нь зүйтэй гэж үзжээ. Түүнчлэн ямар ч арга зам байхгүй гэж хариулсан хүмүүс ч байна. Гэсэн хэдий ч, ЖСХ-ийн үндсэн шалтгаан болох жендэрийн тэгш бус байдал, эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг арилгахыг хэн ч санал болгоогүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.



Зураг 3.11. ЖСХ, ГБХ-ээс урьдчилан сэргийлэх арга зам, хувиар



НЦҮТ /ГБХ-аар үйлчилүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа


### 3.В. Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, хандлага, итгэл үнэмшил

Бид энэхүү судалгаагаараа ЖСХ болон ГБХ-ийн талаарх иргэдийн ойлголт, хандлага, итгэл үнэмшлийг судлахаар олон төрлийн асуулт оруулсан бөгөөд дараах хэд хэдэн асуултыг тавьж санал нийлж байгаа эсэхийг тодрууллаа.

“ЖСХ болон ГБХ-ийн гол буруутан эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй Та санал нийлэх уу?” гэсэн асуултад нийт оролцогчдын 3968 буюу 79.4 хувь нь “ҮГҮЙ” гэсэн байхад 1032 буюу 20.6 хувь нь “ТИЙМ” гэсэн хариултыг өгсөн байна.




Зураг 3.12. ЖСХ, ГБХ-ийн гол буруутан нь эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй санал нийлсэн байдал, хүйсээр



Судалгаанд нийт 1309 (26.2%) эрэгтэй, 3691 (73.8%) эмэгтэй хамрагдсан бөгөөд нийт эрэгтэйчүүдийн 26.2 хувь нь хүчирхийллийн гол буруутан нь эмэгтэйчүүд өөрсдөө мөн гэдэгтэй санал нийлсэн бол эмэгтэйчүүдийн 18.7 хувь нь энэ асуулттай санал нийлжээ. Энэ ойлголттой санал нийлсэн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 7.5 нэгжээр их байна.

Энэ үзүүлэлтийг байршлаар харахад энэ ойлголттой хот, суурин газрынхан илүү санал нийлж байхад, хөдөөгийнхөн хамгийн бага хувь (10.1%)-тай байна.


Зураг 3.13. ЖСХ, ГБХ-ийн гол буруутан нь эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр



ЖСХ болон ГБХ-ийн гол буруутан эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй нийслэлийнхний 21.9 хувь нь санал нийлж байгаа бөгөөд хамгийн өндөр хувьтай байна. Мөн хүйс, байршлаар харахад хөдөөгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн 10.0 орчим хувь нь санал нийлж байна. Сумын төв болон аймгийн төвийн эрэгтэйчүүдийн 27.0 орчим хувь нь санал нийлж байгаа хамгийн өндөр хувьтай байна.

Түүнчлэн насны бүлгээр тооцоход, нас ахих тусам энэ ойлголттой санал нийлэх явдал ажиглагдаж байна (Зураг 3.14).


Зураг 3.14. ЖСХ, ГБХ-ийн гол буруутан нь эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр



Энэ үзүүлэлтийг хүйс болон насны бүлгээр нарийвчлан задалж Зураг 3.15-д үзүүлсэн бөгөөд зургаас харахад ЖСХ болон ГБХ-ийн гол буруутан эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй бүх насны бүлгийн эрэгтэйчүүдийн 20.8-37.5 хувь нь санал нийлсэн байна. Түүний дотор 55-64 болон 75-аас дээш насныхны 30.0-аас дээш хувь нь санал нийлж байгаа бол 25-34 насныхны 25.4 хувь, 15-24 насныхны 27.1 хувь, 35-44 насныхны 28.4 хувь нь санал нийлсэн байна.

Харин эмэгтэйчүүдийн 14.3-27.4 хувь нь өөрсдөө энэ асуулттай санал нийлжээ. Үүний дотор 65-74 насны эмэгтэйчүүдийн 27.4 хувь нь санал нийлсэн нь хамгийн их хувийг эзэлж байна. Залуу эмэгтэйчүүдийн ихэнх нь буюу 81.6-84.4 хувь нь санал нийлэхгүй байна.

Зураг 3.15. ЖСХ, ГБХ-ийн гол буруутан нь эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй санал нийлсэн байдал, хүйс, насны бүлгээр, хувиар




Мөн “Сайн эхнэр санал нийлэхгүй байсан ч нөхрийнхөө саналыг дэмжих ёстой гэдэгтэй Та санал нийлэх үү?” гэсэн асуулттай судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 73.1 хувь нь санал нийлэхгүй байхад 26.9 хувь нь санал нийлсэн байна.

ҮСХ-ноос 2017 онд зохион байгуулж, эмэгтэйчүүдийг хамруулсан “Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа”-гаар энэ төрлийн асуултын дагуу мэдээлэл цуглуулсан бөгөөд нийт эмэгтэйчүүдийн 48.7 хувь нь нөхрийнхөө үгийг дагах ёстой гэж санал нийлсэн байдаг. Харин хүчирхийлэлд өртөөгүй эмэгтэйчүүдийн 47.6 хувь, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 55.4 хувь нь санал нийлсэн байсан.

Энэ удаагийн судалгаагаар дээрх ойлголттой санал нийлж байгаа иргэдийн эзлэх хувь харьцангуй буурч, энэ ойлголттой санал нийлэхгүй байгаа иргэдийн эзлэх хувь нэлээдгүй өсөж 73.1 хувь болсон байна. Эндээс дүгнэхэд ЖСХ болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт, хандлага өөрчлөгдөж байна гэж дүгнэж болохоор байна.

Энэ үзүүлэлтийг судалгаанд хамрагдсан иргэдийн хүйс болон амьдарч буй байршлаар нь задалж харахад эрэгтэйчүүдийн 30.2 хувь нь, эмэгтэйчүүдийн 25.8 хувь нь санал нийлсэн байна. Харин байршлаар харахад сумын төвд амьдарч буй иргэд энэ ойлголттой санал нийлсэн байдал хамгийн их хувийг эзэлж байна.


Зураг 3.16. Сайн эхнэр санал нийлэхгүй байсан ч нөхрийнхөө саналыг дэмжих ёстой гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр, хувиар



Мөн иргэдийн хандлагыг насны бүлгээр авч үзэхэд нас ахих тусам энэ ойлголттой санал нэгдэх байдал нэмэгдэж байгаа хэдий ч 75-аас дээш насныхны хувь нэлээд бага буюу 24.3 хувь нь энэ ойлголттой санал нийлсэн байна.


Залуучууд буюу 15-34 насныхны 21.6-23.4 хувь нь энэхүү ойлголттой санал нийлж, 76.6-78.4 хувь нь санал нийлэхгүй гэж хариулжээ (Зураг 3.17).

Зураг 3.17. Сайн эхнэр санал нийлэхгүй байсан ч нөхрийнхөө саналыг дэмжих ёстой гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр, хувиар



Энэ ойлголттой санал нийлсэн болон нийлээгүй иргэдийг боловсролын түвшнээр харьцуулж тооцсоныг Зураг 3.18-аас харж болно. Иргэдийн боловсролын түвшин дээшлэх тутам энэхүү ойлголттой санал нийлэхгүй байна. Тухайлбал, өөрийнхөө боловсролын түвшинг мэдэхгүй байгаа иргэдийн 42.9 хувь нь энэ ойлголттой санал нийлжээ.

Зураг 3.18. Сайн эхнэр санал нийлэхгүй байсан ч нөхрийнхөө саналыг дэмжих ёстой гэдэгтэй санал нийлсэн байдал, боловсролын түвшинээр, хувиар




“Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа”-ны үр дүнгээр боловсролын түвшин дээшлэх тутам энэ ойлголттой санал нийлэхгүй байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь мөн нэмэгдэж байсан юм.

Тухайлбал, хүчирхийлэлд өртсөн болон өртөөгүйгээс үл хамааран дээд боловсролтой эмэгтэйчүүдийн 34.5-42.4 хувь нь энэ ойлголттой санал нийлж байсан бол боловсрол эзэмшээгүй эмэгтэйчүүдийн 67.7-79.7 хувь нь санал нийлсэн юм.

Өмнө дурдсанчлан, 2019 онд явуулсан энэхүү судалгаагаар энэ ойлголттой санал нийлсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь (25.8 хувь)-ийг 2017 онд зохион байгуулсан ЖСХС-ны үр дүнтэй (47.6-55.4 хувь) харьцуулахад харьцангуй бага байна. Хэдийгээр судалгааны үр дүнд нөлөөлж болохуйц өөрчлөлт арга зүйн хувьд байгаа боловч, 2 судалгаанаас гарсан үр дүн хангалттай ялгаатай гарсан нь энэ 2 жилд эмэгтэйчүүдийн жендерийн талаарх хандлага сайжирсан гэж дүгнэж болохоор байна.


“Эхнэр буруу зүйл хийсэн байвал нөхөр нь зодож, зэмлэж, шийтгэж болно гэдэгтэй Та санал нийлэх үү?” гэсэн асуултад нийт оролцогчдын 94.1 хувь нь санал нийлэхгүй гэж хариулжээ. Эндээс жендерийн хэвшмэл ойлголт монголчуудын хувьд өөрчлөгдөж байна гэж дүгнэж болохоор байна.

Зураг 3.19. Эхнэр буруу зүйл хийсэн байвал нөхөр нь зодож, зэмлэж, шийтгэж болно гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр, хувиар



Энэ үзүүлэлтийг хүйсээр харахад эрэгтэйчүүдийн 93.7 хувь, эмэгтэйчүүдийн 94.2 хувь нь санал нийлэхгүй гэжээ. Мөн байршлаар харахад нийслэл болон хөдөө амьдарч буй иргэдийн 95.5 орчим хувь нь санал нийлэхгүй гэсэн байна.

Зураг 3.20. Эхнэр буруу зүйл хийсэн байвал нөхөр нь зодож, зэмлэж, шийтгэж болно гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр, хувиар



Мөн насны бүлгээр харахад залуучуудын 94.5-96.0 хувь нь санал нийлээгүй байна. Харин 65-74 насны иргэдийн санал нийлэхгүй байгаа хувь хамгийн бага буюу 91.8 хувь байна.

Харин энэ үзүүлэлтийг хөдөлмөр эрхэлж буй болон эрхлээгүй байгаа иргэдийн хувьд тооцоход онцын ялгаа ажиглагдсангүй. Тухайлбал, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн 94.4 хувь нь энэ ойлголттой санал нийлэхгүй байхад хөдөлмөр эрхлээгүй иргэдийн 93.3 хувь нь санал нийлээгүй байна.


“Эхнэр буруу зүйл хийсэн байвал нөхөр нь зодож, зэмлэж, шийтгэж болно”, “Хүчирхийллийг зөвтгөх үндэслэл байж болно” гэсэн эдгээр асуултуудыг ЖСХС-нд оруулаагүй ба 2017 оны судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс “Тодорхой шалтгаанаар нөхөр нь эхнэрээ цохиж, зодох нь зөв үү?” гэж үндсэн 7 чиглэлээр асуухад нийт эмэгтэйчүүдийн 1.6-35.5 хувь нь зөв гэж хариулсан байжээ. Тухайлбал, эхнэрээ өөр эрэгтэйтэй дотно харьцаа үүсгэснийг мэдвэл нөхөр нь зодох нь зөв гэж 22.2-35.5 хувь нь, хүүхдүүддээ анхаарал хандуулахгүй байвал зодох нь зөв гэж 6.1-10.1 хувь нь, нөхрийн үгэнд орохгүй байвал зодох нь зөв гэж 4.2-7.9 хувь нь хариулсан байв. Энэ судалгаа болон ЖСХС-ны хооронд хэдий ялгаатай, шууд харьцуулах боломжгүй хэдий ч ЖСХ, ГБХ-ийг үл тэвчих байдал нэмэгдэж байгааг харуулж байна.

Жендэрийн хэвшмэл ойлголтын талаар судлахын тулд “Зарим тохиолдолд хүчирхийллийг зөвтгөх үндэслэл байж болно гэдэгтэй Та санал нийлэх үү?” гэж асуусан. Энэ асуултын дагуу иргэдийн хандлагыг судлахад оролцогчдын 15.4 хувь нь энэ ойлголттой санал нийлсэн бол 84.6 хувь нь санал нийлээгүй байна.






Зураг 3.21. Хүчирхийллийг зөвтгөх үндэслэл байж болно гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр, хувиар



Хүйсээр харахад эрэгтэйчүүдийн 17.8 хувь, эмэгтэйчүүдийн 14.5 хувь нь санал нийлсэн байна. Байршлын хувьд сумын төв болон аймгийн төвийн иргэдийн 16.0 орчим хувь нь санал нийлжээ. Харин хөдөөгийн иргэдийн 11.2 хувь нь санал нийлсэн нь хамгийн бага хувийг эзэлж байна.

Насны бүлгээр харахад өмнөх асуултад хариулсан байдал хадгалагдаж байна. Тухайлбал, нас ахих тусам эдгээр асуултуудтай санал нийлэх байдал нэмэгдэж байна.

Зураг 3.22. Хүчирхийллийг зөвтгөх үндэслэл байж болно гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр, хувиар




Түүнчлэн “Хүчирхийллийг тэвчсэнээр гэр бүлээ аварч, хүүхдүүдээ өнчрүүлэхгүй гэдэгтэй Та санал нийлэх үү?” гэсэн асуулттай нийт иргэдийн 73.7 хувь нь санал нийлээгүй байна. Үүнийг хүйсээр харахад эрэгтэйчүүдийн 64.7 хувь, эмэгтэйчүүдийн 76.9 хувь нь санал нийлээгүй байна. Мөн байршлаар авч үзэхэд хөдөөгийн иргэдийн 66.3 хувь нь энэ ойлголттой санал нийлээгүй байгаа бөгөөд хамгийн бага хувийг эзэлж байгаа юм (Зураг 3.23). Эндээс харахад хүн ямар ч нөхцөл байдлыг даван туулж, гэр бүлээ салгахгүй байх, үр хүүхдээ өнчрүүлэхгүй байх нь зөв гэж иргэдийн 26.3 хувь нь үзжээ.

Хүүхдээ өнчрүүлэхгүй, гэр бүлээ салгахгүй байх нь хүчирхийллийг тэвчих, хүлээн зөвшөөрөх, нуун дарагдуулах бас нэг шалтгаан болж байна.


Энэ үзүүлэлтийг хүйсээр задлаж харвал 3 эрэгтэй тутмын 1 (35.3%) нь, 4 эмэгтэй тутмын 1 (23.1%) нь энэ асуулттай санал нэгдсэн байна. ЖСХ, ГБХ-ийн талаарх бусад асуултуудтай харьцуулахад иргэдийн нэлээд хувь нь энэ асуулттай санал нэгдсэн байгааг харж болно. Доорх зургаас харахад санал нэгдсэн иргэд хөдөөд хамгийн өндөр хувьтай (33.7%), Улаанбаатар хотод хамгийн бага хувьтай (23.3%)-тай байна.

Зураг 3.23. Хүчирхийллийг тэвчсэнээр гэр бүлээ аварч, хүүхдүүдээ өнчрүүлэхгүй гэдэгтэй санал нийлсэн байдал, байршил, хүйсээр, хувиар



Энэ үзүүлэлтийг насны бүлгээр харахад 15-24 насны залуучуудын 19.8 хувь нь энэ ойлголттой санал нийлсэн байхад 55-74 насныхны 38.1-40.4 хувь нь энэ ойлголттой санал нийлсэн нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.


Зураг 3.24. Хүчирхийллийг тэвчсэнээр гэр бүлээ аварч, хүүхдүүдээ өнчрүүлэхгүй гэдэгтэй санал нийлсэн байдал, насны бүлгээр, хувиар



Дээрх зургаас харахад нас ахих тусам энэ ойлголттой санал нийлэх байдал нэмэгдэж байна. Энэ нь монголчуудын хувьд уламжлалт ёс заншил, жендэрийн хэвшмэл ойлголт ахмад настай хүмүүст хадгалагдсаар байгааг харуулж байна.

Түүнчлэн иргэдийн боловсролын түвшнээр харахад энэхүү ойлголттой санал нийлэх иргэдийн хувьд боловсролын түвшин нөлөөлөхгүй байна (Зураг 3.25). Тухайлбал, техникийн болон мэргэжлийн боловсролоос доош боловсролтой иргэдийн 28.6-33.7 хувь нь энэ ойлголттой санал нийлсэн байхад дээд боловсролтой болон магистр, докторын боловсролтой иргэдийн 16.7-21.8 хувь нь энэ ойлголттой санал нийлсэн байна. Харин өөрийн боловсролоо мэдэхгүй байгаа иргэдийн 14.3 хувь нь санал нийлжээ.

Зураг 3.25. Хүчирхийллийг тэвчсэнээр гэр бүлээ аварч, хүүхдүүдээ өнчрүүлэхгүй гэдэгтэй санал нийлсэн байдал, боловсролын түвшинээр, хувиар




Асуулгын төгсгөлд бид оролцогчдын ерөнхий төлөв байдал болон ирээдүйгээ хэрхэн харж байгаа байдлыг тодорхойлох асуулт оруулсан. Судалгаанд хамрагдсан иргэдээс өрхийн наад захын хэрэгцээгээ хангадаг талаар асуусан бөгөөд нийт иргэдийн 80.3 хувь нь өөрийн амьдарч буй өрх нь өрхийн наад захын хэрэгцээгээ хангаж чадаж байгаа гэж хариулсан байна. Харин 14.4 хувь нь өрхийн наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа гэжээ. Мөн энэ талаар мэдэхгүй байна гэж судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 5.3 хувь нь хариулсан байна.


Мөн иргэдийн ирээдүйд итгэх итгэлийн талаар “Ирэх жилүүдэд амьдрал улам сайхан болно гэдэгтэй Та санал нийлэх үү?” гэж асуухад дараах байдалтай хариулсан байна.

Нийт иргэдийн 72.0 хувь нь “ТИЙМ, санал нийлж байна” гэсэн байхад “ҮГҮЙ, санал нийлэхгүй” гэж 6.5 хувь нь хариулсан байна. Мөн хэвээрээ үргэлжлэх байх гэж 10.1 хувь нь, мэдэхгүй байна гэж 11.4 хувь нь хариулсан байна. Энэхүү судалгааны мэдээлэл цуглуулах ажил нь 2019 оны 12 дугаар сард явагдсан бөгөөд энэ нь КОВИД-19 цар тахлын улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл эхлэхээс хэдэн сарын өмнө болсон үйл ажиллагаа гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

Зураг 3.26. Судалгаанд хамрагдсан иргэдийн ирээдүйд итгэх итгэл, хувиар



Зураг 3.27. Өрхийн наад захын хэрэгцээгээ хангадаг байдал, хүйс, байршлаар, хувиар




Иргэдийн өөрсдийнх нь үнэлж байгаагаар өрхийн наад захын хэрэгцээгээ хангаж чадаж байгаа байдлыг хүйсээр тооцоход эмэгтэйчүүдийн 79.6 хувь, эрэгтэйчүүдийн 82.2 хувь нь өрхийн наад захын хэрэгцээгээ хангаж чадаж байна гэсэн бол тэдний 5.0 орчим хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Байршлаар харахад нийслэлийн иргэдийн 85.5 хувь, аймгийн төвийн иргэдийн 79.0 хувь, сумын төвийн иргэдийн 70.8 хувь, хөдөөгийн иргэдийн 75.3 хувь нь өрхийн наад захын хэрэгцээгээ хангаж чадаж байгаа гэж хариулсан байна. Дээрх зургаас харахад өрхийн хэрэгцээгээ хангаж чадаж байгаа иргэдийн эзлэх хувь хот, суурин газарт өндөр хувьтай байна.

Зураг 3.28. Өрхийн наад захын хэрэгцээгээ хангадаг байдал, боловсролын түвшнээр, хувиар



Зураг 3.28-аас харахад боловсролын түвшин дээшлэх тутам өрхийн наад захын хэрэгцээгээ хангаж чадаж байгаа гэж хариулсан иргэдийн эзлэх хувь нэмэгдсэн байна. Тухайлбал, дээд боловсролтой иргэдийн 84.8 хувь, магистр болон доктор зэрэгтэй иргэдийн 89.9 хувь нь өрхийн наад захын хэрэгцээгээ хангаж байгаа гэсэн байна. Дээд боловсролтой хэдий ч өрхийн наад захын хэрэгцээгээ хангаж чадаж байгаа эсэхээ мэдэхгүй байгаа иргэд цөөнгүй буюу 4.4-4.6 хувийг эзэлж байна.

Зураг 3.29. Ирэх жилүүдэд амьдрал улам сайхан болно гэдэгтэй санал нийлсэн байдал, хүйс, байршлаар, хувиар




Дээрх зургаас иргэдийн ирээдүйдээ итгэх итгэлийг харж болох бөгөөд нийт иргэдийн 72.0 хувь нь ирэх жилүүдэд амьдрал сайхан болно гэдэгт итгэж байгааг өмнө дурдсан. Харин хүйсээр харахад эрэгтэйчүүд ирээдүйдээ илүү итгэлтэй байгаа бол байршлын хувьд нийслэлийн иргэдийн 82.1 хувь нь ирэх жилүүдэд амьдрал сайхан болно гэдэгтэй санал нийлсэн нь хамгийн их хувьтай байна. Харин сумын төвийн иргэдийн 9.0 хувь нь ирэх жилүүдэд амьдрал илүү сайхан болно гэдэгт итгэхгүй байна гэсэн нь хамгийн өндөр хувьтай байна. Харин иргэдийн боловсролын түвшнээр харахад ирээдүйд итгэх итгэлд боловсролын түвшин онцын нөлөө үзүүлэхгүй байна.

## БҮЛЭГ 4. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ БОЛОН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ БОЛОН МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд хамрагдсан иргэдээс төрийн байгууллагатай холбоотой үйл ажиллагаа, тэр дундаа үндэсний хэмжээнд хийгдэж байгаа зарим арга хэмжээ, үйл ажиллагааны талаар асуусан.

Судалгаанд оролцогчдоос ЖСХ, ГБХ-ээс гадна хүний эрхтэй холбоотой ямар нэгэн асуудлаар Хүний эрхийн үндэсний комисст хандаж байсан эсэхийг асуусан. Тухайлбал, “Хүний эрхийн комисст гомдол гаргаж, хандаж байсан уу?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан иргэдийн 90.4 хувь нь “ҮГҮЙ” гэж хариулжээ. Харин 4.7 хувь нь гомдол гаргаж байсан гэж хариулсан байна. Мөн түүнчлэн 4.9 хувь нь гомдол гаргаж болдог гэдгийг бас хэрхэн гомдол гаргахыг мэдэхгүй гэж хариулжээ.

Зураг 4.1. Хүний эрхийн комисст гомдол гаргаж байсан байдал, хувиар



Энэ үзүүлэлтийг хүйс болон насны бүлгээр харахад зөрүү багатай ойролцоо хувьтай байна.

Эхний байдлаар харахад, олон нийт ЖСХ болон ГБХ-ийг хүний эрхийн зөрчил гэж үзэж байгаа байдал болон түүнийгээ бодит амьдрал дээр хэрэгжүүлж, ЖСХ, ГБХ-ийг ХЭҮК-т гомдол байдлаар мэдүүлэх хоёрын хооронд ялгаа байгааг судалгааны үр дүн харуулж байна. Гэсэн хэдий ч судалгаанд оролцогчдын ихэнх нь ЖСХ, ГБХ-ийг гэмт хэрэг гэж үзэх мөн түүнийгээ дагуу цагдаагийн байгууллага болон бусад холбогдох чиглэлийн байгууллагуудад хандаж гомдол гаргах эсхүл ЖСХ, ГБХ-ээс зугтах арга зам болгон авч үзэж буйг онцлох хэрэгтэй.




Түүнчлэн хүний эрхийн зөрчил гэж мэдүүлэхэд ХЭҮК нь хүний санаанд хамгийн түрүүнд орж ирдэг төрийн байгууллага биш бөгөөд мөн олон нийт хүний эрхийн зөрчлийн гомдол гаргах болон тусламж авах гэж огт боддоггүйг судалгааны үр дүн нь харуулж байна гэж ойлгож болох юм. Иймд ХЭҮК-д хүний эрхийг хамгаалах, өөрсдийн үйл ажиллагааны тухай ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх болон мөн тусламж хэрэгтэй болсон үед тэдэнд хандах олон олон арга замуудыг нэмэгдүүлэх боломж байна.

ЖСХ, ГБХ нь гэмт хэрэг гэдгийг мөн түүнчлэн Хүний эрхийн үндэсний комисст гомдол гаргаж болдог талаарх иргэдийн ойлголт хангалттай түвшинд биш тэр тусмаа энэ чиглэлээр хийгдэж байгаа ухуулга, нөлөөлөл, сургалт, сурталчилгаа 24-34 насныханд тэр бүр хангалттай хүрэхгүй байгааг харуулж байна. Тиймээс эдгээр насны залуучуудад энэ талаарх ойлголт, мэдлэгийг хэрхэн хүргэх арга замыг тодорхойлох, хүртээмжтэй, өгөөжтэй арга зүйг сонгож ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Мөн эрх нь зөрчигдсөн ч, хүчирхийлэлд өртсөн ч мэдээлдэггүй байдал харагдаж байна. Энэ нь мөн эрх зүйн мэдлэг дутмаг, мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгуулсан Хамтарсан багийн талаар зарим иргэд мэдээлэл муутай байгааг судалгааны дүнгээс харж болох юм. Тухайлбал, “Хамтарсан баг, ТББ-ын зохион байгуулсан олон нийтийн болон дэмжих бүлэгт орж байсан уу?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 83.1 хувь нь “ҮГҮЙ” гэсэн бол “ТИЙМ” гэж 11.8 хувь нь, харин “ТИЙМ ЗҮЙЛ МЭДЭХГҮЙ” гэж 5.1 хувь нь хариулсан байна. Мөн энэ талаарх ойлголтыг хүйсээр ялгаж харахад онцын ялгаа байхгүй байна. Өөрөөр хэлбэл “ҮГҮЙ” гэж эрэгтэйчүүдийн 82.7 хувь, эмэгтэйчүүдийн 83.3 хувь нь хариулжээ.

Зураг 4.2. Хамтарсан баг, ТББ-ын зохион байгуулсан олон нийтийн болон дэмжих бүлгийн талаарх иргэдийн мэдлэг, хувиар




Мэдээллийг олон нийтэд хэрхэн үр дүнтэй түгээх талаар илүү сайн ойлголттой болохын тулд судалгаанд хамрагдсан иргэдээс дараах мэдээллийг цуглуулав. Судалгааны мэдээлэл цуглуулах үед “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” Дэлхийн нийтийн 16 хоногийн аян өрнөж байсан бөгөөд энэ аяны уриа болох “Ойлгоё, хүндэлье” уриаг сурталчилсан зургийг харуулж, иргэдээс уг зураг, уриалгыг харсан, энэ талаарх мэдээлэл авсан эсэхийг тодруулсан.

Зураг 4.3. “Ойлгоё, хүндэлье” аяны уриа, зураг




Ингэхэд судалгаанд хамрагдсан иргэдийн 75.3 хувь нь энэ аяны талаар ямар нэгэн мэдээлэлтэй байсан бол ердөө 24.7 хувь нь энэ аяны талаар сонсож, харж байгаагүй гэжээ. Харин мэдээлэлтэй байсан иргэдийн 33.4 хувь нь телевизээс, 23.5 хувь нь интернэтээс, 10.0 хувь нь гудамж, талбайд байрлуулсан зурагт хуудаснаас, 4.0 хувь нь бусад газраас, 3.7 хувь нь олон нийтэд зориулсан арга хэмжээнээс мэдсэн гэсэн бол 0.7 хувь нь радио, FM-ээс сонссон гэж хариулжээ. Харин огт хараагүй, сонсоогүй гэж 24.7 хувь нь хариулсан байна. Түүнчлэн бусад гэдэгт авто зам дагуу байрлуусан самбар, автобусны буудал дээр, машин дээр наасан байсан зэргээр хариулжээ (Зураг 4.4).

Зураг 4.4. “Ойлгоё, хүндэлье” уриаг харсан байдал, хувиар



Энэхүү мэдээллийг авсан болон аваагүй иргэдийг байршлаар харахад аймгийн төв, сумын төв, хөдөөгийн иргэд болон нийслэлийн иргэдийн ихэнх нь буюу 30.2-40.7 хувь нь телевизээс уг мэдээллийг авсан бол сумын төв, аймгийн төв, нийслэлийн иргэдийн 19.3-26.9 хувь нь уг мэдээллийг интернэтээс авсан нь нэлээд хувийг эзэлж байна.

Зураг 4.5. “Ойлгоё, хүндэлье” уриаг харсан байдал, байршлаар, хувиар



Нийслэлийн иргэдийн 16.8 хувь нь зурагт хуудаснаас уг мэдээллийг авчээ.

Харин энэ талаарх мэдээлэл аваагүй иргэд хөдөөд өндөр хувийг эзэлж байна. Энэ талаарх мэдээлэл аваагүй иргэд нийслэлд хамгийн бага буюу 17.3 хувийг эзэлж байна.

Эндээс харахад ямар нэгэн мэдээллийг иргэдэд хүргэхийн тулд хаана амьдарч байгаа хэнд зориулж хийх, ямар аргаар замаар хийх нь оновчтой байх талаарх судалгаанд үндэслэж хийх нь үр дүнтэй байхыг харж болно.

Өнөөгийн байдлаар иргэдэд мэдээлэл хүргэхийн тулд телевизийн сувгийг ашиглах нь хамгийн үр дүнтэй нь харагдаж байна. Мөн хот, суурин газрын иргэдэд олон нийтийн сүлжээ, интернэтийг ашиглавал оновчтой байх магадлалтай байна. Хөдөөгийн иргэдэд тэдний гар утсаар дамжуулж мэдээлэл хүргэх нь илүү үр дүнтэй байж болох юм.




## БҮЛЭГ 5. НЦҮТ БОЛОН ТҮР ХАМГААЛАХ БАЙРААР ҮЙЛЧЛҮҮЛСЭН ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ БОЛОН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТӨЖ БАЙСАН БАЙДАЛ

Судалгаанд хамрагдсан нийт иргэдээс ЖСХ болон ГБХ-д өртөж байсан талаар тодруулахаас гадна тухайн орон нутагт Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байр байдаг талаар мэдээлэлтэй эсэхийг тодруулсан. Мөн энэхүү НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлж байсан эсэх, үйлчлүүлж байсан бол үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн байдлыг судалсан.

Судалгааны дүнгээр судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 80.4 (4020 хүн) хувь нь ЖСХ болон ГБХ-д өртөж байгаагүй бол 19.6 (980 хүн) хувь нь өртөж байсан байна. Мөн хүйсээр харахад эрэгтэйчүүдийн 14.8 хувь, эмэгтэйчүүдийн 21.3 хувь нь хүчирхийлэлд өртөж байжээ. Энэ үзүүлэлтийг байршлаар харвал нийслэлийн иргэд ЖСХ, ГБХ-д харьцангуй бага (12.1 хувь) өртсөн гэсэн бол хөдөөгийн иргэд хамгийн их хувьтай (31.5 хувь) байна.

Зураг 5.1. ЖСХ болон ГБХ-д өртөж байсан эсэх, байршил, хүйсээр, хувиар




Зургаас харахад ЖСХ, ГБХ-д эмэгтэйчүүд илүү өртөж байгаа нь харагдаж байна.

Харин насны бүлгээр авч үзвэл 35-44 насны иргэдийн 23.2 хувь нь хүчирхийлэлд өртсөн байгаа нь хамгийн их хувьтай байна. Цаашилбал, 45-54 насныхны 20.3 хувь, 25-34 насныхны 19.8 хувь, 75-86 насныхны 18.9 хувь нь хүчирхийлэлд өртсөн байна. Түүнчлэн залуучууд буюу 15-24 насныхны 16.4

хувь хүчирхийлэлд өртжээ. Мөн ЖСХС-ны үр дүнгээр 40-44 насны эмэгтэйчүүд хамтрагчийн хүчирхийлэлд хамгийн их өртсөн байсан нь энэ судалгааны үр дүнгээс бас харагдаж байна.

Зураг 5.2. ЖСХ болон ГБХ-д өртөж байсан эсэх, насны бүлгээр, хувиар



Энэ судалгаанд хамрагдсан иргэдийн 19.6 хувь нь ЖСХ, ГБХ-д өртсөн гэж хариулсан бол 2017 онд үндэсний хэмжээнд зохион байгуулсан ЖСХС-гаагаар Монгол Улсын эмэгтэйчүүдийн 57.9 хувь нь амьдралынхаа туршид хамтрагчийн зүгээр үзүүлсэн ямар нэгэн хэлбэрийн хүчирхийлэлд дор хаяж нэг удаа өртсөн гэж хариулсантай харьцуулахад эрс ялгаатай байгааг тэмдэглэх нь зүйтэй. Энэ 2 судалгааны үр дүнг байршил, насны бүлэг болон бусад задаргаагаар харахад мөн ялгаатай харагдаж байна.

Эдгээр зөрүү нь судалгааны арга зүй тухайлбал, судалгаанд хамрагдагчдыг сонгосон байдал, асуулт, агуулгын зөрүүтэй байдал зэрэгтэй холбоотой байж болох юм. Энэхүү судалгаанд хамрагдсан иргэдээс шууд л “Та ЖСХ болон ГХБ-д өртөж байсан уу?” гэж асуусан бол ЖСХС-д хамрагдсан эмэгтэйчүүдээс 5 төрлийн хүчирхийлэл (бие махбодын, бэлгийн, сэтгэл зүйн, эдийн засгийн болон хянах зан үйлд)-д өртсөн байдлыг үйлдлээр тодорхойлж асуусан. Өөрөөр хэлбэл ЖСХС-д хүчирхийлэл гэдэг үгийг ашиглаагүй болно.


Энэ судалгааны зорилго нь ЖСХ, ГБХ-д өртсөн иргэдэд үзүүлсэн үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлоход оршиж байсан. Иймээс судалгаанд хамрагдсан, ЖСХ болон ГБХ-д өртөж үйлчилгээ авсан иргэдийн нийгэм, хүн ам зүйн байдлыг тодорхойлох, илүү нарийвчилсан шинжилгээ хийхийг зорьсон юм. Монгол Улсын хэмжээн дэх хүчирхийллийн тархалт, хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулсан ЖСХС-ны үр дүнгээр тодорхойлж явах нь оновчтой юм.



Судалгаанд хамрагдсан иргэдээс ЖСХ болон ГБХ-д өртсөн эсэхийг асуухаас гадна тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ, ТХБ-ны талаар иргэд хэр зэрэг мэдээлэлтэй байгааг судалсан.

Зураг 5.3-т тодорхойлсны дагуу нийт иргэдийн 59.6 хувь нь энэ талаар ямар ч мэдээлэлгүй гэж хариулжээ. Харин 35.0 хувь нь энэ талаар мэдээлэлтэй, харин 5.4 хувь нь орон нутгийнхаа НЦҮТ болон ТХБ-ны талаар мэддэг бөгөөд очиж үйлчлүүлж байсан гэж хариулсан байна.

Зураг 5.3. Оршин суугаа аймаг/дүүрэгт нь НЦҮТ болон ТХБ байдаг талаарх мэдээлэлтэй иргэд, хувиар




### 5.А. Хүчирхийлэлд өртөж, НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн, нэмэлт асуулгад хариулсан иргэд

Судалгаагаар хүчирхийлэлд өртөөд, НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдээс өөрсдийнх нь зөвшөөрлийн үндсэн дээр нэмэлт асуултуудыг асуусан билээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн 324 (судалгаанд хамрагдсан иргэдийн 6.5 хувь) нь ямар нэгэн төрлийн хүчирхийлэлд өртөж, НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлж байсан тул нэмэлт асуултад хариулахаар сонгогдсон. Харин эдгээр иргэдээс 169 буюу 52.2 хувь нь нэмэлт асуултад хариулахаар зөвшөөрсөн юм.

Эдгээр иргэдээс тухайн үйлчлүүлсэн төвийнх нь талаарх мэдээллийг авах нэмэлт асуултад хамрагдах саналыг асууж, нэмэлт судалгаанд хамруулсан.


Зураг 5.4. Нэмэлт асуулгад сонгогдсон иргэд болон хариулахыг зөвшөөрсөн байдал, хувиар



Нэмэлт асуултад сонгогдоогүй иргэд 93.5 хувь байгаа бөгөөд энэ нь судалгаанд хамрагдсан нийт иргэдээс тооцсон дүн болно. Тухайлбал, энэ нь судалгаанд хамрагдсан нийт 5000 иргэнээс хүчирхийлэлд өртөөгүй нийт иргэдийн эзлэж буй хувь юм.

Энэхүү нэмэлт асуултад хариулахаар зөвшөөрсөн иргэдийн 85.8 хувь нь эмэгтэй, 14.2 хувь нь эрэгтэй байна. Энэ нь хөдөөгийн иргэдийн 11.2 хувь, сумын төвийн иргэдийн мөн 11.2 хувь, аймгийн төвийн иргэдийн 61.5 хувь, хотын иргэдийн 16.0 хувийг эзэлж байна.

Зураг 5.5. Нэмэлт асуулгад хариулахыг зөвшөөрсөн эсэх, хүйс, байршлаар, хувиар




НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдээс нэмэлт асуултад хариулахыг зөвшөөрсөн иргэдийг хүйсээр харвал 5 эмэгтэй тутмын 3 нь зөвшөөрсөн байхад, 10 эрэгтэй тутмын 3 нь зөвшөөрсөн байна (Зураг 5.5). Мөн байршлаар нь харвал хөдөөгийн иргэдийн 82.6 хувь нь зөвшөөрсөн байхад сумын төв болон нийслэлийн иргэдийн дөнгөж 41.5-42.2 хувь нь зөвшөөрчээ.

Насны бүлгээр харахад нэмэлт судалгаа өгөхөөр зөвшөөрсөн иргэдийн дунд 25-34 насныхан 33.7 хувийг эзэлж байгаа нь хамгийн их хувьтай байгаа бол 65-74 насныхан 1.2 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага хувьтай байна.



Зураг 5.6. Нэмэлт асуулгад хариулахыг зөвшөөрсөн эсэх, насны бүлгээр, хувиар



Энэ үзүүлэлтийг насны бүлгээр тооцоход нас ахих тутам нэмэлт асуултад хариулахыг зөвшөөрсөн иргэдийн эзлэх хувь буурсан байна.

### 5.В. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамж

Өмнөх хэсэгт дурдсаны дагуу хүчирхийлэлд өртөөд, НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдээс үйлчлүүлсэн төвийнх нөхцөл байдал болон авсан үйлчилгээ, сэтгэл ханамжийн талаарх нэмэлт асуултыг асуусан. Мөн НЦҮТ, ТХБ-ны талаарх мэдээллийг хаанаас, хэнээс авсан талаар асууж тодруулсан.

Одоогийн байдлаар манай улсад нийт 29 НЦҮТ, ТХБ үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээрийн 9 нь Улаанбаатар хотод, бусад 20 нь аймгийн төвд байна. Эдгээрийн 17 (6 нь Улаанбаатарт, 11 нь аймгийн төвд) нь энэхүү судалгаанд хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан зөвхөн 17 төвийг үнэлсэн болно.

Зураг 5.7-оос харахад иргэд НЦҮТ болон ТХБ-ны талаарх мэдээллийг албан болон албан бус байдлаар маш олон сувгаар олж авдаг байна.


Зураг 5.7. НЦҮТ болон ТХБ-ны талаарх мэдээллийг авсан эх сурвалж, хувиар



Эдгээр иргэдийн 3 хүн тутмын 1 нь НЦҮТ, ТХБ-ны талаарх мэдээллийг найз, нөхдөөсөө авсан байна. Мөн олон нийтэд зориулсан арга хэмжээнээс нийт иргэдийн 16.0 хувь нь уг мэдээллийг олж авчээ. Түүнчлэн 14.8 хувь нь телевизээс, 8.3 хувь нь ажлын хамт олон болон бусад танилаасаа, 5.9 хувь нь аав, ээжээсээ, 3.0 хувь нь интернэтээс, 1.2 хувь нь ах, эгч, дүү нараасаа, 0.6 хувь нь FM радио зэргээс холбогдох мэдээллийг олж авсан байна. Эндээс харахад олон нийтийг хамарсан сургалт, сурталчилгааны ажил иргэдэд нэлээдгүй мэдээлэл өгч байгааг харж болох юм.


Харин 20.7 хувь нь бусад сувгаар НЦҮТ, ТХБ-ны талаарх мэдээллийг олж авсан байна. Бусад гэдэгт баг, хорооны ажилтнаас, багшийн төвөөс, лавлах утаснаас, цагдаа, цагдаагийн байгууллагаас, эмнэлгийн ажилтнаас олж мэдсэн гэж хариулсан байна.

Зураг 5.8. НЦҮТ болон ТХБ-ны талаарх мэдээллийг авсан эх сурвалж, байршлаар, хувиар



Дээрх зурагт НЦҮТ, ТХБ-ны талаарх мэдээллийг иргэд хаанаас олж авч байгааг байршлаар харуулсан ба нийслэлийн 3 иргэн тутмын 1 нь тус бүр телевиз болон найз, нөхдөөсөө уг мэдээллийг авсан байна. Харин аймгийн төвийн 3 иргэн тутмын 1 нь мөн найз, нөхдөөсөө, сумын төвийн 5 иргэн тутмын бараг 2 нь олон нийтэд зориулсан арга хэмжээнээс хөдөөгийн 3 иргэн тутмын нэг нь тус бүр найз, нөхөд болон бусад сувгаар уг мэдээллийг олж авчээ.

Зураг 5.9. НЦҮТ болон ТХБ-ны талаарх мэдээллийг авсан эх сурвалж, хүйсээр, хувиар



Энэ үзүүлэлтийг хүйсээр харахад найз, нөхдөөсөө болон бусад сувгаар энэ талаарх мэдээлэл авсан гэж хариулсан иргэдийн эзлэх хувь бараг ялгаагүй байна. Харин аав, ээжээсээ тухайн мэдээллийг авсан гэж хариулсан эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэлээд их байхад олон нийтэд зориулсан арга хэмжээнээс уг мэдээллийг авсан эмэгтэйчүүдийн эзлэх хувь их буюу 17.2 хувь байна.


НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдээс тухайн төвөөр хэдэн удаа үйлчлүүлснийг тодруулахад иргэдийн 61.5 хувь нь анх удаа, 16.6 хувь нь 2 дахь удаагаа, 8.9 хувь нь 3 дахь удаагаа, 13.0 хувь нь 4, түүнээс олон удаа үйлчлүүлсэн байна (Зураг 5.10).

Зураг 5.10. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, үйлчлүүлсэн давтамжаар



НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн үйлчлүүлсэн давтамжийг хүйс болон байршлаар харахад эмэгтэйчүүдийн 56.8 хувь, эрэгтэйчүүдийн 79.2 хувь нь анх удаа үйлчлүүлсэн байна. Доорх зургаас харахад эмэгтэйчүүдийн давтан үйлчлүүлсэн хувь эрэгтэйчүүдийнхээс харьцангуй их байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн 19.3 хувь нь 2 дахь удаагаа, 8.3 хувь нь 3 дахь удаагаа, 13.8 хувь нь 4-өөс олон удаа үйлчлүүлсэн байна. Энэхүү үр дүнд үндэслэн тооцоход эмэгтэйчүүдийн 41.4 хувь нь давтан үйлчлүүлсэн бол эрэгтэйчүүдийн 20.8 хувь нь давтан үйлчлүүлжээ. Эндээс харахад хүчирхийлэл нь дахин давтан үйлдэгдэж, хүний эрхийг дахин давтан зөрчиж байдаг хүний эрхийн томоохон зөрчил болох нь харагдаж байна.


Зураг 5.11. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, хүйс, байршил, давтамжаар, хувиар



Харин байршлаар харахад хөдөөгийнхөөс бусад байршилд байгаа иргэдийн 40.4-42.1 хувь нь дахин давтан үйлчлүүлсэн байна. Хөдөөгийн иргэдийн давтан үйлчлүүлсэн хувь хамгийн бага буюу 21.0 хувь байгаа нь НЦҮТ, ТХБ амьдарч байгаа газраас нь хол, тэнд хүрэх боломж хязгаарлагдмал байдагтай холбоотой байж болох юм.

Мөн энэ үзүүлэлтийг насны бүлгээр харахад нас ахих тусам олон удаа үйлчлүүлсэн давтамж нь ихэссэн байна. Өөрөөр хэлбэл 65-74 насны иргэдийн 50.0 хувь нь 3 удаа, 50 хувь нь 4-өөс олон удаа НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн байна. Харин 75-аас дээш настай 3 иргэн тутмын 2 нь хоёр болон түүнээс олон удаа үйлчлүүлсэн байна. Доорх зургаас харахад залуучууд буюу 15-24 насны иргэдийн 25.9 хувь нь, 25-34 насны залуусын 28.1 хувь нь давтан үйлчлүүлсэн байна. Эндээс дүгнэхэд өндөр настай иргэд хүчирхийлэлд дахин давтан өртсөөр байгаа бөгөөд энэ нь үр хүүхдүүдээс нь үзүүлж байгаа хүчирхийлэл байх магадлалтай юм. Түүнчлэн монголын ирээдүй болсон залуус ч дахин давтан хүчирхийлэлд өртсөн байдал харагдаж байна (Зураг 5.12).

Зураг 5.12. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, насны бүлэг, давтамжаар, хувиар



Эдгээр үр дүнгээс 2 дүгнэлт гаргаж болохоор байна. Нэгдүгээрт, залуу насны хүмүүсийн дунд НЦҮТ, ТХБ-аар нэг удаа үйлчлүүлсэн нь дийлэнх хувийг эзэлж байгаа хэдий ч тэд аль хэдийн хүчирхийлэлд өртсөн байгаа нь түгшүүр төрүүлж байна. Энэ нь нас ахих тусам дахин давтан болон үргэлжлүүлэн хохирогч болох мөн НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлэх давтамж нэмэгдэх эрсдэлтэй байгааг харуулж байна. Хоёрдугаарт, ихэнх НЦҮТ, ТХБ нь сүүлийн 10 жилийн хугацаанд байгуулагдсан ба энэ нь өндөр настай иргэд зөвхөн энэ хугацаанд тус төвүүдээр үйлчлүүлсэн байх магадлалтайг харуулж байна. Иймээс өндөр настны эсрэг ЖСХ, ГБХ-ийг тэдний хүүхдүүд нь үйлдэж байж болзошгүй юм.

Бид НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдээс үйлчлүүлэхээр ирсэн зорилго болон тухайн үед ямар нөхцөл, байдалтай ирсэн талаар тодруулан асуусан.

Зураг 5.13. НЦҮТ болон ТХБ-нд ирсэн нөхцөл, байдал, хувиар




НЦҮТ/ТХБ-аар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж болон олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх судалгаа



Үйлчилгээ авахаар ирэхдээ иргэдийн 37.3 хувь нь гэр, орондоо байх аргагүй болсон, 21.3 хувь нь хүчирхийлэлд өртөөд гэмтсэн, 10.7 хувь нь нуугдах, 30.7 хувь нь бусад нөхцөл байдалтай ирсэн гэжээ.

Эдгээр иргэдийг хүйсээр харахад эмэгтэйчүүдийн 35.9 хувь, эрэгтэйчүүдийн 45.8 хувь нь гэр, орондоо байх аргагүй болсон байна. Харин эрэгтэйчүүдийн хувьд бусад гэсэн нөхцлийг 41.7 хувь нь хэлжээ. Бусад гэдэг нөхцөлд баримт бичгээ бүрдүүлэх, зөвлөгөө авах, судалгаанд хамрагдах, эмнэлэгт үзүүлэх зорилгоор очсон гэжээ.

Зураг 5.14. НЦҮТ болон ТХБ-нд ирсэн нөхцөл, байдал, хүйс, байршлаар, хувиар



Байршлаар харахад гэр, орондоо байх аргагүй болсон гэсэн хариултыг сумын төв болон аймгийн төвийн иргэд их өгсөн бол хөдөөгийн иргэд хүчирхийлэлд өртөөд гэмтсэн нөхцөлд НЦҮТ, ТХБ-нд их ирдэг байна. Тухайлбал, хөдөөгийн иргэдийн 68.4 хувь нь хүчирхийлэлд өртөөд гэмтсэн тул тус төвд ирсэн байна. Эндээс харахад хөдөөгийн иргэдийн хувьд тус төв нь эмнэлгийн үйлчилгээ авахад чухал үүрэгтэй газар болохыг илтгэж байна.


Мөн НЦҮТ, ТХБ-д иргэд ирэхдээ ямар зорилгоор ирж байгааг судалсан бөгөөд иргэдийн 78.1 хувь нь хамгаалуулахаар, 18.3 хувь нь очих газар байгаагүй тул, 3.6 хувь нь амьд үлдэхийг хүссэн тул тус төвд очсон байна. Эндээс НЦҮТ, ТХБ нь маш чухал байгаа бөгөөд ЖСХ, ГБХ-д өртөж байгаа иргэдийн амь насыг хамгаалж байдгааг чухалчилмаар байна.

Зураг 5.15. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн зорилго, хувиар



Энэ үзүүлэлтийг хүйс болон байршлаар харахад эмэгтэйчүүдийн 80.6 хувь, эрэгтэйчүүдийн 62.5 хувь нь хамгаалуулахаар очжээ. Харин амьд үлдэхийн тулд эмэгтэйчүүдийн 2.8 хувь нь очсон бол эрэгтэйчүүдийн 8.3 хувь нь энэ шалтгааныг дурдсан байна.

Зураг 5.16. НЦҮТ болон ТХБ-нд ирсэн зорилго, хүйс, байршлаар, хувиар



Байршлын хувьд нийслэл болон аймгийн төвийн иргэдийн 3.7 орчим хувь нь амьд үлдэхийн тулд очсон гэсэн бол сумын төвийн иргэдийн 5.3 хувь нь энэ хариултыг өгсөн байна.


Харин доорх зурагт төвд ирсэн иргэдийн зорилгыг насны бүлгээр харуулсан ба 25-44 насны иргэд л амьд үлдэхийн тулд НЦҮТ, ТХБ-нд очсон гэж хариулжээ.





Энэ нь хүчирхийллийн дор амьдарч, амиа алдах хүртэл нөхцөл байдалд орсон залуучууд байсаар байгааг харуулж байна. Иймээс хүчирхийллийг таслан зогсоох ажлыг эрчимтэй хийх шаардлага байсаар байна.

Зураг 5.17. НЦҮТ болон ТХБ-нд ирсэн зорилго, насны бүлгээр, хувиар



НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн авсан үйлчилгээ болон иргэдийн өгсөн үнэлгээний талаарх мэдээллийг энэхүү хэсэгт оруулж байна. Тухайлбал, иргэд НЦҮТ, ТХБ-нд ирээд ямар төрлийн үйлчилгээ авсан, хүссэн үйлчилгээгээ авч чадсан эсэх, мөн тухайн байгууллагын үйлчилгээ болон ажиллагчдын ажлын ур чадвар, мэдлэг, хандлагын талаар дараах үнэлгээнүүдийг өгч байна. Мөн эдгээр үнэлгээг үйлчлүүлсэн иргэдийн хүйс болон амьдарч буй байршил, насны бүлгээр тодорхойлон гаргалаа.


Зураг 5.18. НЦҮТ болон ТХБ-нд ирээд авсан үйлчилгээ, хувиар



НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд тус газарт ирээд 4 төрлийн үйлчилгээ авсан байна. Үйлчлүүлсэн иргэдийн 34.3 хувь нь хамгаалуулсан, 27.2 хувь нь бусад төрлийн зөвлөгөө авсан, 14.8 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ, 8.9 хувь нь хууль, эрх зүйн үйлчилгээ авсан бол 14.8 хувь нь бусад үйлчилгээ авсан байна.


Үйлчилгээ авсан байдлыг хүйс болон байршлаар харахад эмэгтэйчүүдийн ихэнх буюу 37.2 хувь нь хамгаалуулах үйлчилгээ авсан байхад эрэгтэйчүүдийн бараг тал хувь нь зөвлөгөө авсан байна. Харин байршлаар харахад хөдөөгийн иргэдийн ихэнх нь хамгаалуулах үйлчилгээ (84.2 хувь) авч байхад сумын төвийн иргэдийн 63.2 хувь нь зөвлөгөө авсан байна. Аймгийн төв болон нийслэлийн иргэд ихэвчлэн зөвлөгөө авах, хамгаалуулах үйлчилгээ авдаг байна.

Зураг 5.19. НЦҮТ болон ТХБ-нд ирээд үйлчилгээ авсан иргэд, хүйс, байршлаар, хувиар




НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдээс уг төв нь “Таны бодлоор үйлчилгээгээ бүрэн үзүүлсэн үү?” гэж асуухад иргэдийн 76.3 хувь нь бүрэн үйлчилгээ, 23.7 хувь нь бүрэн үйлчилгээгээ үзүүлээгүй гэжээ. Энэ үзүүлэлтийг хүйсээр харахад эрэгтэйчүүдийн 29.2 хувь, эмэгтэйчүүдийн 22.8 хувь нь үйлчилгээгээ бүрэн үзүүлж чадаагүй гэж хариулсан байна. Харин байршлаар авч үзвэл сумын төв болон хөдөөгийн иргэд үйлчилгээгээ бараг бүрэн үзүүлсэн гэж үзэж байхад аймгийн төв болон нийслэлийн иргэдийн 70.2-74.1 хувь нь үйлчилгээгээ бүрэн үзүүлсэн гэжээ.

Зураг 5.20. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд үйлчилгээгээ бүрэн авсан байдал, хүйс, байршлаар, хувиар




Харин одоо НЦҮТ болон ТХБ-нд ирээд авахыг хүссэн үйлчилгээгээ авсан байдлыг харуулъя. Иргэдээ “НЦҮТ, ТХБ-д ирээд авахыг хүссэн ч авч чадаагүй үйлчилгээ бий юу?” гэж асуусан бөгөөд иргэд өөрийн хүсэж байсан үйлчилгээгээ авсан байдлыг Зураг 5.21-ээс харж болно. Ингэхэд нийт иргэдийн талаас илүү хувь (52.7 хувь) нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авсан гэсэн бол 34.9 хувь нь заримыг нь авсан, 12.4 хувь өөрийн хүссэн үйлчилгээгээ огт авч чадаагүй гэж хариулсан байна.

Зураг 5.21. НЦҮТ болон ТХБ-нд ирээд хүссэн үйлчилгээгээ авсан байдал, хувиар



Харин хүйс болон байршлаар харахад эмэгтэйчүүдийн 52.4 хувь, эрэгтэйчүүдийн 54.2 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авсан байна. Хүссэн үйлчилгээгээ огт авч чадаагүй гэж эмэгтэйчүүдийн 11.0 хувь, эрэгтэйчүүдийн 20.8 хувь нь хариулжээ. Мөн байршлаар авч үзэхэд хөдөөгийн иргэдийн 84.2 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авсан байхад нийслэлийн иргэдийн 66.7 хувь, сумын төв болон аймгийн төвийн иргэдийн 42.1-45.2 хувь нь үйлчилгээгээ бүрэн авсан гэжээ.


Зураг 5.22. НЦҮТ болон ТХБ-нд ирээд хүссэн үйлчилгээгээ авсан байдал, хүйс, байршлаар, хувиар



Мөн хүссэн үйлчилгээгээ огт авч чадаагүй гэж аймгийн төв болон нийслэлийн иргэдийн 14.8-16.8 хувь нь хариулсан бөгөөд хөдөөгийн болон сумын төвийн иргэд энэ хариултыг өгөөгүй байна. Эндээс харахад аймгийн төв болон нийслэлийн иргэд өндөр шаардлага тавьдаг байж магадгүй байна.

Түүнчлэн насны бүлгээр харвал 65-аас дээш насныхны дийлэнх нь өөрийн хүссэн үйлчилгээгээ бүрэн авсан гэж үзсэн бол 35-54 насныхны 15.2-18.5 хувь нь хүссэн үйлчилгээгээ огт авч чадаагүй гэж хэлсэн нь хамгийн өндөр хувьтай байна. Мөн 75-86 насныхны 3 хүн тутмын 1 нь хүссэн үйлчилгээгээ огт авч чадаагүй гэжээ (Зураг 5.23).

Зураг 5.23. НЦҮТ болон ТХБ-нд ирээд хүссэн үйлчилгээгээ авсан байдал, насны бүлгээр, хувиар




НЦҮТ, ТХБ-нд ирээд хүссэн үйлчилгээгээ авч чадаагүй гэж хариулсан иргэдээс авч чадаагүй үйлчилгээний талаар хэлэхийг хүссэн. Ингэхэд “айдсаасаа салж чадаагүй, сэтгэл санааг дэмжих байдал байгаагүй, эрүүл мэндийн үйлчилгээ авч чадаагүй болон олон үйлчилгээ авч чадаагүй тухайлбал, эхнэрт арга хэмжээ аваагүй” зэрэг хариултуудыг өгсөн байна.

Судалгаанд хамрагдсан төвүүдийн үйл ажиллагааны талаар үйлчилгээ авсан иргэдийн өгсөн үр дүнг энэ хэсэгт танилцуулж байна.


Судалгаанд хамрагдсан 17 НЦҮТ болон ТХБ-ны үйл ажиллагаанд үйлчлүүлсэн иргэд дараах үнэлгээг өгч байна. НЦҮТ, ТХБ-ны үйлчилгээг дараах 5 төрлөөр дүгнэсэн. Үүнд: үйлчилгээ үзүүлэгчдийн хандлага, харилцаа, мэдлэг, туршлага, үйлчилгээний чанар, байрны тохижилт, нууцлал, аюулгүй байдал зэрэг болно. Үйлчилгээ тус бүрийг 1-9 онооны хооронд үнэлсэн болно. Хамгийн сайныг 9-өөр, хамгийн мууг нь 1-ээр үнэлэв.

Энэ 5 төрлийн үйлчилгээнд дунд зэрэг буюу 5 гэсэн үнэлгээг иргэдийн 25.4-30.8 хувь нь өгсөн байна. Харин маш сайн буюу 9 гэсэн оноог 22.5-27.8 хувь нь өгчээ (Зураг 5.24-5.28). Үйлчилгээ үзүүлж буй ажиллагчдын мэдлэг, туршлагын байдалд үйлчлүүлсэн иргэд харьцангуй өндөр үнэлгээ өгсөн хэдий ч тэдний харилцаа, хандлагын үнэлгээнд арай бага үнэлгээ өгчээ.


Зураг 5.24. Үйлчилгээ үзүүлэгчдийн хандлага, харилцаанд өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар




Зураг 5.25. Үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг, туршлагад өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар




Зураг 5.26. Үйлчилгээний чанарт өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар



Зураг 5.27. Байрны тохижилтод өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар



Зураг 5.28. Нууцлал, аюулгүй байдалд өгсөн үнэлгээ, оноогоор, хувиар



Харин нэлээд муу буюу 1-4 гэсэн үнэлгээг үзүүлэлт тус бүр дээр үйлчлүүлсэн нийт иргэдийн 10.1-14.2 хувь нь өгсөн байна.


Үнэлгээнээс харахад эрх нь зөрчигдсөн, хүчирхийлэлд өртсөн иргэдийг хамгаалах чиглэлээр НЦҮТ, ТХБ-ыг шинээр байгуулж, эдгээр нь хүчин чадлынхаа хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч цаашид тус байгууллагуудын хүчин чадал, хүний нөөц зэрэг бусад шаардлагатай чадавхийг нэмэгдүүлэх шаардлага нэлээдгүй байна.

НЦҮТ, ТХБ-ны үйлчилгээний чанар, байрны тохижилт, нууцлал, аюулгүй байдал зэрэгт иргэд дээрх үнэлгээг өгсөн байна. Тухайлбал, тухайн үйлчлүүлсэн байгууллагын үйлчилгээний чанар болон байрны тохижилтод үйлчилгээ авсан 3 иргэн тутмын 1 нь дунд буюу 5 оноо өгсөн бол 4 иргэн тутмын 1 нь нууцлал, аюулгүй байдалд энэ оноог өгчээ. Харин дээрх 3 үзүүлэлтэд боломжийн, сайн (6-аас дээш оноо) гэсэн үнэлгээг үйлчлүүлсэн иргэдийн 60.0 орчим хувь нь өгсөн байна.


НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлж, үнэлгээ өгсөн иргэдийг байршлаар харахад (Зураг 5.29-5.33) хөдөөгийн иргэд байрны тохижилт болон үйлчилгээнд өндөр үнэлгээ өгсөн бол аймгийн төв болон нийслэлийн иргэд харьцангуй бага үнэлгээ өгсөн байна. Тухайлбал, доорх 5 төрлийн үйлчилгээнд сумын төвийн иргэд 26.3-52.6 нь дундаж буюу 5 оноо өгсөн байхад хотын иргэдийн 25.9-37.0 хувь нь дундаж гэсэн үнэлгээ өгчээ.

Үйлчилгээ авсан иргэдийн 13.6-14.2 хувь нь хангалтгүй буюу 1-4 оноог боловсон хүчний мэдлэг, туршлага болон байрны тохижилтод өгсөн нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Үүнээс дүгнэхэд НЦҮТ, ТХБ-ны тохижилт, үйлчилгээ болон хүчин чадал, боловсон хүчний мэдлэг, чадавхийг сайжруулах, ажиллагчдыг тогтвортой ажиллах нөхцөл, бололцоогоор хангах шаардлагатай байгааг харуулж байна. Мөн тус байгууллагад ирээд эрүүл мэндийн үйлчилгээ авч чадаагүй гэж хариулсан тохиолдол хэд хэд гарлаа.

Зураг 5.29. Үйлчилгээ үзүүлэгчдийн хандлага, харилцаанд өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар




Зураг 5.30. Үйлчилгээ үзүүлэгчдийн мэдлэг, туршлагад өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар







Зураг 5.31. Үйлчилгээний чанарт өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар



Зураг 5.32. Байрны тохижилтод өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар




Зураг 5.33. Нууцлал, аюулгүй байдалд өгсөн үнэлгээ, байршлаар, хувиар




Мөн эдгээр байгууллагын давуу болон сул талын аль их байгаа талаар асуухад иргэдийн 54.4 хувь нь давуу тал нь их, 15.4 хувь нь сул тал нь их гэсэн бол мэдэхгүй гэж 30.2 хувь нь хариулжээ (Зураг 5.34). Харин сул тал нь их болон мэдэхгүй гэж эрэгтэйчүүд илүүтэй хариулсан байна. Харин байршлын хувьд хөдөөгийн иргэд сул тал байхгүй гэж хариулсан бол сул тал нь их гэсэн хариултыг нийслэлийн иргэд их өгчээ. Мөн түүнчлэн мэдэхгүй гэсэн хариултыг аймгийн төвийн иргэдийн 37.5 хувь өгсөн нь хамгийн их хувийг эзэлж байна. Мөн хотын иргэдийн 22.2 хувь сул болон давуу талын аль нь их байгааг хариулж чадаагүй байна.

Зураг 5.34. НЦҮТ болон ТХБ-ны давуу болон сул талыг үнэлсэн байдал, хүйс, байршлаар, хувиар



НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсний дараа иргэдийн амьдралд өөрчлөлт гарсан эсэхийг тодруулахад иргэдийн 56.2 хувь нь эерэг өөрчлөлт гарсан, 40.2 хувь нь ямар нэгэн өөрчлөлт гараагүй гэжээ. Харин нэлээд бага буюу 3.6 хувь нь улам дордсон гэж хариулсан байна.

Зураг 5.35. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлснээр гарсан өөрчлөлт, хүйс, байршлаар, хувиар




Харин хүйсээр харахад эрэгтэйчүүдийн 8.3 хувь, эмэгтэйчүүдийн 2.8 хувь нь улам дордсон гэж, ямар нэгэн өөрчлөлт гараагүй гэж эмэгтэйчүүдийн 41.3 хувь, эрэгтэйчүүдийн 33.4 хувь нь хариулжээ. Мөн эерэг өөрчлөлт гарсан гэж хариулсан эрэгтэйчүүдийн эзлэх хувь эмэгтэйчүүдийнхээс их байна.

Байршлаар авч үзвэл хөдөөгийн болон сумын төвийн иргэдээс улам дордсон гэсэн хариултыг өгөөгүй байна. Харин аймгийн төвийн иргэдийн 4.8 хувь, хотын иргэдийн 3.7 хувь нь нөхцөл байдал улам дордсон гэж хариулжээ. Харин байршлаас үл хамаарах иргэдийн ихэнх нь (50.0-68.4 хувь) эерэг өөрчлөлт гарсан гэж хариулсан байна Аймгийн төвийн иргэдийн тал хувь нь эерэг өөрчлөлт гарсан гэж хариулсан нь хамгийн бага хувьтай байна.

Түүнчлэн насны бүлгээр харахад нас ахих тутам буюу 54 нас хүртэл эерэг өөрчлөлт гарсан гэж хариулсан иргэдийн хувь аажмаар буурч, өөрчлөлт гараагүй хэвэндээ байсан гэж хэлсэн иргэдийн хувь нэмэгдсэн байна. Харин энэ байгууллагаар үйлчлүүлснээр нөхцөл байдал улам дордсон гэж 35-44 насныхны 8.7 хувь нь хариулсан хамгийн их хувийг эзэлж байна.

Зураг 5.36. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлснээр гарсан өөрчлөлт, насны бүлгээр, хувиар



Эерэгээр нөлөөлсөн гэж хариулсан иргэдийн хувьд тухайн гэр бүлийн хүүхдүүд нь тайвширч, тайван амьдрах болсон, сэтгэл зүйн хувьд тайвширсан, цаашид хүчирхийлэлд өртөөд энэ чигээрээ байх боломжгүй гэдгийг ойлгосон, харьцангуй тайван байдаг болсон, бусдыг өөрөөр хардаг болсон, өөртөө итгэлтэй болсон, бие биетэйгээ ойлголцох хүсэлтэй болсон, бусад хүмүүст мэдээлэл өгөх чадвартай болсон, гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдлэгтэй болсон, сэтгэл санааны дарамтнаас чөлөөлөгдсөн, гэр бүлийнхээ хүнд хүчирхийллийн талаар, түүнчлэн эмэгтэй хүний үнэ цэнийг мэдрүүлсэн, гэр бүлээ хамгаалж чаддаг болсон, гэрт хэрүүл багассан, нөхөр маань өөрчлөгдсөн, архи уухаа больсон, нэг нэгэндээ буулт сайн хийж чаддаг болсон, сурч боловсрох сонирхолтой болсон, хамгаалах газартай гэдгийг мэдрүүлсэн, хууль эрх зүйн мэдлэгтэй болсон, хүүхэд аюулгүй болсон, юмыг өөдрөгөөр хардаг болсон зэргээр хариулжээ.


## БҮЛЭГ 6. НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ БОЛОН ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮНЭЛГЭЭ

Бид судалгаагаараа жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэг, хандлагыг судлахын зэрэгцээ нийслэл болон аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ болон ТХБ-ны талаарх мэдээллийг цуглуулж, холбогдох асуултын дагуу үнэлгээ хийлээ.

Судалгаанд хамрагдсан 17 НЦҮТ, ТХБ-ны 10 буюу 58.9 хувь нь 2016 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. НЦҮТ, ТХБ-аар сүүлийн 3 жилд ирж үйлчүүлсэн хүмүүсээс түүврээр сонгож судалгаанд хамрууллаа.

Нийт 5 аймгийн НЦҮТ, ТХБ-ыг НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр эхлүүлж байсан байна. Харин 2018-2019 онд нийт 7 аймаг болон Улаанбаатар хотод нийт 9 НЦҮТ-ийг байгуулжээ.

Зураг 6.1. НЦҮТ болон ТХБ-ны тоо, байгуулагдсан оноор




Дээрх зургаас харахад Монгол Улсад НЦҮТ болон ТХБ анх 2009 онд байгуулагдсан байна. Өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ болон ТХБ-ны бараг 30.0 (5) хувь нь 2019 онд байгуулагдсан байна. Тухайлбал, ЖСХС-ны үр дүнд үндэслэн 2018-2019 онд нийт 9 төвийг нийслэл болон аймгийн төвд байгуулсан.

Монгол Улсын хэмжээнд 2014 онд нийт 6 төв байсан бол 2019 оны байдлаар НЦҮТ болон ТХБ-ны тоо 18 (3 дахин) болж өссөн байна. Харин 2019 онд нийт 2118 иргэн 17 төвөөр үйлчлүүлсэн бөгөөд 2014 онтой харьцуулахад эдгээр

төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо 2.1 дахин өсжээ. Зураг 6.2-оос харахад сүүлийн 6 жилийн байдлаар тус төвүүдээр үйлчлүүлэгчдийн тоо тогтмол өссөөр байна. Үйлчлүүлэгчдийн тоо өсөхөд шинээр төвүүд бий болсон нь нөлөөлсөн байна. 2019 оны байдлаар үйлчилгээ авсан нийт иргэдийн 1697 (80.1 хувь) нь эмэгтэйчүүд, 421 (19.9 хувь) нь эрэгтэйчүүд байна.

Үйлчлүүлсэн иргэдийг 2014 онтой харьцуулан хүйсээр харахад эмэгтэйчүүд 2.0 дахин, эрэгтэйчүүд 2.4 дахин өссөн байна. Эрэгтэйчүүд гэдэгт ихэвчлэн хүүхдүүд багтаж байна (Зураг 6.2). Эндээс дүгнэхэд тус төвүүдээр үйлчлүүлдэг хүүхдийн тоо нэлээд өссөн байгаа нь харагдаж байна. Үйлчлүүлсэн иргэдийн тоог оноор харахад 2015 онд өмнөх оноос 289 хүн буюу 28.4 хувь, 2016 онд 314 хүн буюу 24.0 хувь, 2017 онд 74 хүн буюу 4.6 хувь, 2019 онд 580 буюу 37.7 хувиар өсжээ. Хамгийн их өсөлт нь 2019 онд байгаа бөгөөд тус төвүүдээр үйлчлүүлсэн иргэд 37.7 хувиар өссөн байна.

Зураг 6.2. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо, хүйсээр, 2014-2019 он




Харин 2018 онд төвүүдээр үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оноос 158 хүн буюу 9.3 хувиар буурсан байна.

Зураг 6.3-аас харахад НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна. Тухайлбал, ШШҮХ болон Дорнод, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн НЦҮТ, ТХБ-аар 2019 онд үйлчлүүлсэн иргэд бүгд эмэгтэйчүүд байна.


Харин Өмнөговь аймгийн НЦҮТ-өөр үйлчлүүлсэн 2 хүн тутмын нэг нь эрэгтэйчүүд байсан бол бусад аймаг болон нийслэлийн НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн 55.9-88.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 6.3. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, аймаг, нийслэл, хүйсээр, хувиар, 2019 он



Мөн НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийг 2017 болон 2018 оны байдлаар харахад үйлчлүүлэгчдийн ихэнх нь эмэгтэйчүүд байсан байна.

Зураг 6.4. НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд, аймаг, нийслэл, хүйсээр, хувиар, 2017-2018 он





Зургаас харахад Хан-Уул дүүргийн НЦҮТ-өөр үйлчлүүлэгчдийн 2 хүн тутмын 1 нь эрэгтэйчүүд байгаа нь харагдаж байна. Энэ төв нь Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн харьяа НЦҮТ бөгөөд энэ төвд хүүхдүүд их үйлчлүүлдэг юм. Иймээс эрэгтэй үйлчлүүлэгчид нь ихэвчлэн хүүхдүүд байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүмүүс үйлчлүүлсэн байна.

Энэ үзүүлэлтийг хүйсээр харахад эдгээр төвүүдээр үйлчлүүлсэн эмэгтэйчүүд 2016 болон 2019 онд 30.0 орчим хувиар өссөн нь хамгийн их өсөлттэй жил байжээ. Харин тус төвүүдээр үйлчлүүлсэн эрэгтэйчүүдийн хувьд 2019 хамгийн их буюу 76.9 (183 эрэгтэй) хувийн өсөлттэй байна.

Мэдээлэл цуглуулсан НЦҮТ болон ТХБ-ны мэдээллээс нийт үйлчлүүлэгчдийн тоонд хүүхдүүд багтаж байгаа тул үйлчлүүлсэн эрэгтэйчүүд их байсан мэтээр харагдаж байна. Харин эмнэлэг түшиглэсэн НЦҮТ-ийн үйлчлүүлэгчдийн ихэнх нь эмэгтэйчүүд байгааг *Зураг 6.4*-өөс харж болно. Тухайлбал, Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн харьяа НЦҮТ-д 2019 онд 110 хүн ирж үйлчлүүлсний 97 нь буюу 88.2 хувь нь хүүхдүүд байна.

Судалгаанд хамрагдсан НЦҮТ, ТХБ-ны хүчин чадлыг тодорхойлохын тулд хүлээн авах хүний тоо буюу орны тоо, гал тогооны, чөлөөт цагийн болон хүүхдэд зориулсан өрөөтэй эсэх, байрны өмчлөл, сууцны болон гадна талбайн хэмжээ зэргийг тодорхойлсон.

НЦҮТ, ТХБ-ны сууцны талбай болон гадна талбайн хэмжээний талаарх мэдээллийг дараах хүснэгтэд харууллаа. Эндээс харахад Хөвсгөл болон Дархан-Уул аймгийн НЦҮТ-ийн байр хамгийн том буюу 400 метр квадратаас дээш хэмжээтэй байна.

### Хүснэгт 6.1. НЦҮТ болон ТХБ-ны хэмжээ

№	НЦҮТ болон ТХБ	Сууцны талбай (м <sup>2</sup> )	Гадна талбай (м <sup>2</sup> )
1	Хөвсгөл аймгийн НЦҮТ	465	-
2	Дархан-Уул аймгийн НЦҮТ	400	700
3	Өвөрхангай аймгийн НЦҮТ	204	300
4	Завхан аймгийн НЦҮТ	192	600
5	Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн НЦҮТ	134	185
6	Баянхонгор аймгийн НЦҮТ	120	428
7	Архангай аймгийн НЦҮТ	112	120
8	Өмнөговь аймгийн НЦҮТ	104	400
9	Хэнтий аймгийн НЦҮТ	80	1600
10	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг түшиглэсэн НЦҮТ	60	-
11	ГССҮТ-ийн НЦҮТ	35	-
12	ШШҮХ-гийн НЦҮТ	32	1600
13	СБД - Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ	-	-
14	Дорнод аймгийн НЦҮТ	-	-
15	Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа ТХБ	-	4063
16	Баян-Өлгий аймгийн НЦҮТ	-	-
17	БЗД-ийн НЦҮТ	-	228



Харин Нийслэлийн цагдаагийн газрын харьяа ТХБ-ны гадна талбай хамгийн том буюу 4063 метр квадрат хэмжээтэй, үүний дараа Хэнтий аймаг болон ШШҮХ-гийн НЦҮТ-ийн гадна талбай хамгийн том буюу 1600 метр квадрат хэмжээтэй байна.

Сууцны талбайн хэмжээ бичигдээгүй НЦҮТ тухайлбал, эмнэлэг түшиглэсэн төвүүдийн хувьд эмнэлгийн дотор үйл ажиллагаагаа явуулж байгаа тул тусгайлсан өөрийн байр гэж үзэхгүй байгаа учраас сууцны дотор талбайн хэмжээг тусгаагүй болно. Түүнчлэн ШШҮХ-ийн гадна талбай гэдэгт тухайн байгууллагын нийт гадна талбайн хэмжээг тусгалаа.

Мөн төвүүдийн хүчин чадал, багтаамжийн Хүснэгт 6.2-оос харж болно. Судалгаанд хамрагдсан 17 газраас Нийслэлийн цагдаагийн газрын харьяа ТХБ нь хүн хүлээн авах хүчин чадал буюу орны хувьд өнөөдрийн байдлаар хамгийн их буюу 30 ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ байгууллага нь улсын хэмжээнд хамгийн том хэмжээний байртай хэдий ч хүүхдийн өрөө болон чөлөөт цагийн өрөө байхгүй байна. Харин гал тогооны өрөө боломжийн тогтмол үйл ажиллагаатай ажиллаж байна.

Хүснэгт 6.2. НЦҮТ болон ТХБ-ны хүчин чадал

№	НЦҮТ болон ТХБ	Орны тоо	Гал тогооны өрөөтэй эсэх	Хүүхдийн өрөөтэй эсэх	Чөлөөт цагийн өрөөтэй эсэх
			Тийм=1, Үгүй=2		
1	Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа ТХБ	30	1	2	2
2	Дархан-Уул аймгийн НЦҮТ	24	1	1	1
3	Баян-Өлгий аймгийн НЦҮТ	12	1	2	1
4	Архангай аймгийн НЦҮТ	12	1	1	1
5	Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн НЦҮТ	10	1	2	1
6	Өвөрхангай аймгийн НЦҮТ	10	1	1	1
7	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг түшиглэсэн НЦҮТ	8	1	1	1
8	Баянхонгор аймгийн НЦҮТ	8	1	2	2
9	Хөвсгөл аймгийн НЦҮТ	8	1	1	2
10	Завхан аймгийн НЦҮТ	6	1	1	1
11	Дорнод аймгийн НЦҮТ	6	1	2	2
12	ГССҮТ-ийн НЦҮТ	4	2	2	2
13	Хэнтий аймгийн НЦҮТ	4	1	1	2
14	Өмнөговь аймгийн НЦҮТ	4	1	2	1
15	БЗД-ийн НЦҮТ	4	1	2	1
16	СБД - Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ	2	2	2	2
17	ШШҮХ-гийн НЦҮТ	0	2	2	2
Нийт тоо		152	14	7	9
Дүнд эзлэх хувь			82.4	41.2	52.9

Үүний дараа 2018 онд шинээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн Дархан-Уул аймгийн НЦҮТ нь 24 хүн нэгэн зэрэг хүлээн авах чадалтай буюу ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн энэ газар нь хүүхдийн тусдаа өрөө,

үйлчлүүлэгчид чөлөөт цагаа өнгөрүүлэх өрөөтэй, гал тогооны тусдаа өрөөтэй зэргээрээ үйлчлүүлэгчдийн тав тухыг бүрэн хангах, үйлчилгээгээ бүрэн үзүүлэх боломжоор бүрдсэн байна. Үүний зэрэгцээ хөдөө, орон нутагт байгуулагдсан хамгийн том төв болсон байна.

Мөн Баян-Өлгий болон Архангай аймгийн НЦҮТ нь 12 ортой, Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн харьяа НЦҮТ болон Өвөрхангай аймгийн НЦҮТ тус бүр 10 ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Түүнчлэн ШШҮХ-гийн харьяа НЦҮТ нь үйлчлүүлэгчээ байрлуулж, хонуулах 4 ортой, тусгай өрөөтэй байсан хэдий ч 2019 оноос эхлэн эмнэлгийн удирдлага тухайн өрөө байх шаардлагагүй, энд хонуулах боломжгүй гэдэг шалтгаанаар өрөөг эмнэлгийн ажилтны өрөө болгон өөрчилсөн байна. Иймээс хохирогчдыг байрлуулах боломжгүй болсон. Мөн энэ төв нь бичиг баримтгүй хүмүүст шууд үйлчилгээ үзүүлж байна.


Нийслэлийн Гэмтэл, согог судлалын төв(ГССҮТ)-ийн НЦҮТ нь Филиппинийн туршлагыг судалж, тус орны туршлагын дагуу тохижуулсан 5 тохилог бөгөөд хамгаалалтын дохиолол суурилуулсан өрөөтэй үйл ажиллагаагаа явуулж байгаад 2018 онд эмнэлгийн удирдлага солигдсоны дараа тохижилт бүхий 3 өрөөг эмнэлгийн үйл ажиллагаа явуулахаар хураан авсан байна.

Дээрх хүснэгтээс харахад бусад НЦҮТ нь 2-8 ортойгоор үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 17 газраас 14 газар нь гал тогооны өрөөтэй, 7 газар нь хүүхдийн өрөөтэй, 9 нь үйлчлүүлэгчид чөлөөт цагаа өнгөрүүлэх өрөөтэй байна. Харин эмнэлэг түшиглэсэн 3 төв нь гал тогооны тусдаа өрөөгүй байна.

Эдгээрээс дүгнэхэд тухайн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын удирдлагын ойлголт, хандлага зэргээс төвүүдийн хүчин чадал, үйл ажиллагаа ихээхэн хамаарч байна. Мөн Монгол Улсын хувьд улс төрийн нөлөөллөөр байгууллагын удирдлага, боловсон хүчний өөрчлөлт хүртэл хийгдэж эдгээр төвүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь цаашлаад хүчирхийлэл болон ямар нэгэн эрсдэлд орсон иргэдийг хамгаалах үйл ажиллагаанд муугаар нөлөөлөхийн зэрэгцээ, хөрөнгө, мөнгөө зарцуулж, хүчээ дайчлан бүтээн бий болгосон байгууламжийг үгүй хийж байна.

НЦҮТ болон ТХБ нь боловсон хүчин буюу ажиллагчдын тооны хувьд дутагдалтай ажиллаж байгаа бөгөөд Зураг 6.5-т судалгаанд хамрагдсан 17 НЦҮТ, ТХБ-ны ажиллагчдын тоог харууллаа. Тухайлбал, хамгийн их буюу 23 ажилтантай 1 байгууллага байна. Харин 1 ажилтантай 1 байгууллага, 2-3 ажилтантай байгууллага нийтдээ 6 байна. Мөн 6, 10, 12 ажилтантай тус бүр 1 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 6.5. НЦҮТ болон ТХБ-ны ажиллагчдын тоо болон давтамж



Мөн үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ болон ТХБ-нд очсон судлаачид өөрсдийн үнэлгээг гаргалаа. Энэхүү үнэлгээг Тохижилт болон Үйлчилгээ гэсэн 2 төрлөөр үнэлж гаргасан (Хүснэгт 6.3, 6.4). Эндээс харахад тохижилтын хувьд 6 буюу дундаас дээш үнэлгээг нийт 14 төв авсан байна. Тохижилтын хувьд 2 гэсэн үнэлгээг ШШҮХ-ийн НЦҮТ, 4 гэсэн үнэлгээг Архангай аймгийн НЦҮТ, 5 гэсэн үнэлгээг Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн НЦҮТ-д өгсөн байна. Түүнчлэн НЦҮТ болон ТХБ-нд байгаа мэдээлэл, сурталчилгааны тарааж өгөх материал болон мэдээлэл, сурталчилгааны самбарын ашиглалтад харьцангуй бага үнэлгээ өгсөн байна.

Хүснэгт 6.3. НЦҮТ болон ТХБ-ны тохижилтонд судлаачийн өгсөн үнэлгээ

№	НЦҮТ болон ТХБ	Үзүүлэлтүүд				
		Байрны тохижилт	Үйл ажиллагааны тогтвортой байдал	Мэдээлэл, сурталчилгааны тарааж өгөх материал	Байранд байгаа мэдээлэл, сурталчилгааны самбарын ашиглалт, баяжуулалт	Байрны нууц байдал болон хамгаалалт/ хамгаалалтын систем
1	Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа ТХБ	6	9	6	5	9
2	ГССҮТ-ийн НЦҮТ	6	9	9	9	5
3	Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн НЦҮТ	5	9	5	7	1
4	СБД - Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ	6	8	5	6	5
5	ШШҮХ-ийн НЦҮТ	2	9	2	2	9
6	БЗД-ийн НЦҮТ	9	9	6	6	9
7	Архангай аймгийн НЦҮТ	4	6	5	7	7
8	Баян-Өлгий аймгийн НЦҮТ	7	7	7	1	9
9	Баянхонгор аймгийн НЦҮТ	6	8	5	5	7
10	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг түшиглэсэн НЦҮТ	8	8	9	8	7
11	Завхан аймгийн НЦҮТ	8	5	5	5	5
12	Дархан-Уул аймгийн НЦҮТ	9	9	9	9	9
13	Дорнод аймгийн НЦҮТ	9	8	9	9	9
14	Өвөрхангай аймгийн НЦҮТ	9	8	8	8	9
15	Өмнөговь аймгийн НЦҮТ	8	6	8	8	8
16	Хөвсгөл аймгийн НЦҮТ	9	9	8	8	8
17	Хэнтий аймгийн НЦҮТ	8	8	7	7	8

Харин үйл ажиллагааны тогтвортой байдал, байрны нууц байдал болон хамгаалалт, хамгаалалтын системийн хувьд төвүүдэд харьцангуй өндөр үнэлгээ өгсөн байна. Тухайлбал, үйл ажиллагааны тогтвортой байдлын хувьд 5 гэсэн үнэлгээг 1 төвд өгсөн бол бусад төв нь 6-аас дээш үнэлгээ авжээ. Хамгийн бага буюу 5 гэсэн үнэлгээг Завхан аймгийн НЦҮТ-д өгсөн байна. Байрны нууц байдал болон хамгаалалтын хувьд 1 гэсэн үнэлгээ авсан нэг төв байгаа бөгөөд энэ нь Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн НЦҮТ байна. Тус төв нь тохижилт болон хамгааллын хувьд хамгийн бага үнэлгээ авсан шалтгаан нь гадна талбай байхгүй, тохижуулах боломжгүй, хамгаалалтын хувьд тус байрны цонхнууд нь шууд гадна орчинтой харьцаж байгаа бөгөөд ямар ч цонхны хаалт, хамгаалалт байхгүй байгаа учраас бага үнэлгээ авсан. Харин энэ төвийн дотор тохижилт боломжийн байсан бөгөөд үйл ажиллагаагаа харьцангуй тогтвортой явуулж, байнгын үйлчлүүлэгчтэй ажиллаж байсан. Гадна тохижилт, хамгаалалтын хувьд бага үнэлгээ өгсөн нь энэ төвийн ажил муу гэсэн утгыг илэрхийлэхгүй бөгөөд цаашид эдгээр зүйлд анхаарч, тохижуулах, сайжруулах шаардлага байгааг илтгэж байгаа юм.

#### Хүснэгт 6.4. НЦҮТ болон ТХБ-ны үйлчилгээнд судлаачийн өгсөн үнэлгээ

№	НЦҮТ болон ТХБ	Үзүүлэлтүүд						
		Аюулгүй байдлын хамгаалалт	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	Сэтгэл зүйн үйлчилгээ	Нийгмийн халамжийн үйлчилгээ	Хүүхэд хамгааллын үйлчилгээ	Эрх зүйн тусалцаа	Холбон зуучлах үйлчилгээ
1	Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа ТХБ	9	8	9	8	8	8	9
2	ГССҮТ-ийн НЦҮТ	8	9	9	6	8	7	8
3	Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн НЦҮТ	1	4	8	7	6	8	8
4	СБД - Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ	5	9	6	5	5	6	6
5	ШШҮХ-гийн НЦҮТ	9	9	9	9	8	9	9
6	БЗД-ийн НЦҮТ	9	8	8	6	8	7	8
7	Архангай аймгийн НЦҮТ	9	8	9	7	8	8	8
8	Баян-Өлгий аймгийн НЦҮТ	9	9	9	9	9	9	9
9	Баянхонгор аймгийн НЦҮТ	7	5	8	6	5	6	7
10	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг түшиглэсэн НЦҮТ	8	9	9	5	9	8	8
11	Завхан аймгийн НЦҮТ	5	5	5	5	5	5	5
12	Дархан-Уул аймгийн НЦҮТ	9	9	9	9	9	9	9
13	Дорнод аймгийн НЦҮТ	8	8	8	8	8	8	8
14	Өвөрхангай аймгийн НЦҮТ	9	8	9	9	9	9	9
15	Өмнөговь аймгийн НЦҮТ	8	5	7	8	8	8	8
16	Хөвсгөл аймгийн НЦҮТ	8	8	8	8	8	8	8
17	Хэнтий аймгийн НЦҮТ	8	8	8	8	8	8	8

НЦҮТ болон ТХБ-ны аюулгүй байдал, харуул, хамгаалалтын хувьд өөрийн харьяа цагдаагийн газрын дэргэд, ойролцоо байдаг тул тайван, аюул багатай байдаг гэсэн хариултыг өгч байсан.



Хүснэгтээс харахад НЦҮТ болон ТХБ-ны үзүүлж буй үйлчилгээнд судлаачид харьцангуй өндөр үнэлгээг өгсөн байгаа нь бүгд 5-аас дээш үнэлгээ өгснөөр харагдаж байна.

Эдгээр НЦҮТ болон ТХБ-ны хувьд 2020 онд яаралтай хийх тулгамдсан асуудлууд байна гэж бүгд үзсэн байна.

*Хүснэгт 6.5. НЦҮТ болон ТХБ-нд хийх шаардлагатай үйл ажиллагаа*

№	НЦҮТ болон ТХБ	Өгсөн санал, ач холбогдлоор				
		1	2	3	4	5
1	Архангай аймгийн НЦҮТ	Тохижилт	Мэргэжлийн боловсон хүчин	Үйл ажиллагаагаа тогтвортой ажиллуулах санхүүжилт		
2	Баян-Өлгий аймгийн НЦҮТ	Номын сантай болох (Иргэдийг сургах, завгүй байлгах)	Интернэт	Оёдлын машинтай болох	Орон тооны ажилтантай болох	Үндсэн орон тоо, нийгмийн ажилтантай болох
3	Баянхонгор аймгийн НЦҮТ	2 давхарт цонхны төмөр хаалт хийх	Урсгал засвар хийх	Эрүүл мэндийн ажилтны өрөөг тохижуулах (Тоног, төхөөрөмж)	Тээврийн хэрэгсэлтэй болох	Хувьсах зардлыг нэмэгдүүлэх
4	БЗД-ийн НЦҮТ	Машинтай болох				
5	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг түшиглэсэн НЦҮТ	Мөнгө, санхүүгийн хэлтэс	Камер байршуулан, цагдаатай холбох	Байраа тохижуулж, өөрийн байртай болох	Ард иргэдэд сургалт зохион байгуулах	
6	ГССҮТ-ийн НЦҮТ	Ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө	Орон байрны стандарт алдагдсан	Хүний нөөц, орон тоог хангаж ажиллах (Сэтгэл зүйч гм)	НЦҮТ-ийн санхүүжилтийг нэн шаардлагатай шийдвэрлэх	
7	Дархан-Уул аймгийн НЦҮТ	Ногоо тарихад шаардлагатай хүлэмж	Хашааны тохижилт	ЕБС-ийн сурах бичиг (1-12)	Амьдрах ухааны сургалтад зориулж оёдлын машин	
8	Дорнод аймгийн НЦҮТ	Ажилчдын орон тоог нэмэгдүүлж 4 болгох	Халаалт сайжруулах (Төвийн шугамд холбогдох)	Хүүхдийн тоглоомын талбай шинэчлэх	Яаралтай дохиолол хэрэгтэй	
9	Завхан аймгийн НЦҮТ	Эмчийн үзлэгийн болон хүүхдийн тоглоомын өрөөг тохижуулах	НЦҮТ-ийн төсөв (Орон нутаг)	Сургалтын хэрэглэгдэхүүн	Зарим тоног төхөөрөмж (Компьютер, зургийн аппарат)	
10	Нийслэлийн Цагдаагийн газрын харьяа ТХБ	Төсөвт зардал суулгуулах (Санхүүжилт)	Байрны газрыг өөрсдийн өмчийнх болгох			
11	Өвөрхангай аймгийн НЦҮТ	Орон тооны асуудал шийдвэрлэх	Ажилчдыг чадавхжуулах	Татвар суурьшилтай ажиллуулах	Ажилчдын аюулгүй байдлыг хангах	
12	Өмнөговь аймгийн НЦҮТ					
13	СБД - Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ	Санхүүжилт, хүний нөөц	Хамгаалах өрөөний тохижилт (Тоон системийн кабел, )	Хүүхдийн хичээл хийх ширээ, сандал	Хичээлийн хэрэгсэл	Хүүхэд суух, тоглох зөөлөн эвлүүлдэг гудас
14	Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн НЦҮТ	Гадна талбайн тохижилт (Битүү хашаа, хаалттай байх-Цонхонд төмөр хаалт хийх)	Гадна бетон хаяавч, дээвэр засах (Барилгын насжилт дууссан)	Хүүхдийн тоглоом, хэрэгсэл, хувцас	Гадна хашаа, агаарлах талбайтай болох	Орон тоо нэмэх (эмч, хамгаалалт гм)
15	Хөвсгөл аймгийн НЦҮТ	Стандартад нийцсэн засвар тохижилтын ажил	Албан хаагчдын цалин	НДШ болон үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг шийдвэрлэх		
16	Хэнтий аймгийн НЦҮТ	Ажлын байр нэмэгдүүлэх				
17	ШШҮХ-гийн НЦҮТ	Сэтгэл зүйн зөвлөгөөний стандарт өрөө, тасалгаатай болох				

Түүнчлэн НЦҮТ, ТХБ-ны хувьд цаашид зайлшгүй бөгөөд ойрын хугацаанд хийх ажлууд байгааг дурдаж байсан. Эдгээр ажлыг Хүснэгт 6.5-д НЦҮТ болон ТХБ бүрээр жагсаалаа.

НЦҮТ болон ТХБ-ны хүчин чадал нь тэдгээр төвүүдийг харьяалж ажилладаг байгууллага, агентлагын удирдлагаас гадна эдгээр үйлчилгээний төвийн төсвийг улсын болон орон нутгийн түвшинд хуваарилдаг улс төрийн шийдвэр гаргагчдаас инхээхэн хамаарч байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй байна.

Шийдвэр гаргагчид ЖСХ ба ГБХ-ийг онцгойлон авч үзсэн нөхцөлд л НЦҮТ болон ТХБ-ууд нь хүний нөөц болон тохижилт хоёрын хоёуланд нь зориулагдсан хангалттай төсвийн тогтвортой хөрөнгө оруулалтад үндэслэн үйл ажиллагаагаа тогтвортойгоор явуулах, өргөтгөх боломжтой болох юм.

Иймээс НЦҮТ, ТХБ байр нь ЖСХ, ГБХ-д өртсөн хүмүүст чанартай үйлчилгээг үргэлжлүүлэн хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгааг болон цаашид зайлшгүй хэрэгцээ байгааг эдгээр шийдвэр гаргагчдад сурталчлан таниулах нь чухал юм.



## БҮЛЭГ 7. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨГӨӨ

Үндэсний статистикийн хороо нь ЖСХ болон ГБХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагыг үнэлэх, мөн түүнчлэн хүчирхийлэлд өртсөн иргэдэд үйлчилгээ үзүүлдэг НЦҮТ, ТХБ-ны чанарт үнэлгээ хийх зорилгоор уг судалгааг зохион байгууллаа. Судалгааг 2019 оны 11-12 сард зохион байгуулсан ба судалгаанд Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, 21 аймгийн 5000 орчим иргэдийг хамруулсан. Мөн судалгаагаар НЦҮТ, ТХБ-ны нөхцөл байдал, үйлчилгээний хүртээмж, чанарт судлаачид үнэлгээ өгч ажилласан.

Судалгаанаас гарсан үндсэн үр дүн болон зөвлөмжийг доор тусгалаа.

### ***ЖСХ болон ГБХ-ийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлага***

- ЖСХ болон ГБХ-ийн талаар өөрсдийгөө үнэлэх асуултад иргэдийн 45.0 хувь нь мэдлэгийн түвшнээ “дундаж”, 31.9 хувь нь “дунджаас дээгүүр”, 23.1 хувь нь “дунджаас доогуур” гэж хариулсан байна. Гэсэн хэдий ч ЖСХ, ГБХ-ийн талаарх тодорхой асуултад судалгаанд хамрагдагчдын ихэнх нь үнэн зөв, тодорхой хариултыг өгч чадаагүй байсан. Энэ нь судалгаанд оролцогчдын ЖСХ болон ГБХ-ийн талаарх ойлголт, үзэл баримтлал нь тэдний бодит мэдлэг болон тэдний мэдлэгийн түвшин 2-ын хооронд нэлээд зөрүүтэй байгааг илтгэж байна.
- Жендэрийн тэгш бус байдал, хүчний тэнцвэргүй байдал нь ЖСХ-ийн суурь шалтгаан боловч энэ судалгаанд хамрагдсан хүмүүс ЖСХ, ГБХ-ийн үндсэн шалтгаан юу гэсэн асуултад зөв, тодорхой хариултыг өгч чадаагүй байна. Тухайлбал, иргэдийн 40.0 орчим хувь нь ЖСХ, ГБХ-ийн суурь шалтгааныг архи, архидалт, мансуурч, согтуурах явдал гэж буруу тодорхойлсон бол 43.0 хувь нь хүмүүс хоорондын харилцаа, үйл ойлголцол, сэтгэл зүйн хүчин зүйлүүд гэжээ. Харин судалгаанд оролцогчдын цөөн хувь нь ажилгүйдэл (5.9 хувь), боловсрол муу байгаагаас (2.6 хувь), ядуурал, амьдралын түвшин доогуур байдал (1.1 хувь) зэрэг нийгмийн хүчин зүйлийг тодорхойлж хэлсэн байна.
- ЖСХ, ГБХ үйлдэгч хэн байж болох талаар иргэдээс асуухад нийт иргэдийн 37.5 хувь нь ер нь хүчирхийлэгч нь хэн ч байж болно гэсэн байна. Мөн айл гэрийн тэргүүн, нөхөр/зөвхөн эрэгтэйчүүд (32.4 хувь), тухайлбал аав гэж 6.2 хувь нь, эхнэр буюу зөвхөн эмэгтэйчүүд гэж 7.1 хувь нь, тухайлбал ээж гэж 3.1 хувь нь хариулжээ. Түүнчлэн хүчирхийлэл үйлдэгчийг олон төрлөөр тодорхойлсон бөгөөд архи уусан хэн бүхэн (3.3 хувь нь), сэтгэцийн өвчтэй хүн (0.4 хувь нь) гэж хариулсан байна.

- Судалгаанд оролцогчдоос жендэрийн тэгш бус байдлын талаар хэд хэдэн асуулт (ЖСХ, ГБХ-д эмэгтэйчүүдийг өөрсдийг нь буруутгах, хүчирхийллийг тодорхой нөхцөлд зөвтгөх гэх мэт)-ыг асууж, тухайн ойлголтуудтай санал нийлж байгаа эсвэл нийлэхгүй байгааг нь тодруулсан. Ингэхэд судалгаанд хамрагдсан иргэдийн ихэнх (73.1-84.6 хувь) нь жендэрийн тэгш бус байдалтай санал нийлэхгүй байна гэж хариулсан байгааг тэмдэглэхэд таатай байна.
- ◆ ҮСХ-ноос 2019 онд зохион байгуулсан энэ судалгаа (47.6-55.4 хувь)-г 2017 оны ЖСХС-тай харьцуулахад арга зүйн хувьд ялгаатай тухайлбал, шууд харьцуулах боломжгүй асуулт, өгүүлбэрүүдийг асуусан хэдий ч жендэрийн тэгш бус байдлыг хүлээн зөвшөөрсөн иргэдийн эзлэх хувь нэлээд ялгаатай байгааг тэмдэглэх нь зүйтэй. **Энэ нь Монголчуудын жендэрийн талаарх хандлага, итгэл үнэмшил сүүлийн 2 жилд зөв болж, сайжирж байгааг харуулж байна.**
- ЖСХ болон ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ямар арга зам байгааг асуухад оролцогчид ихэвчлэн сургалт, сурталчилгаа хийх, телевиз болон интернэтээр сурталчлах, сургууль, ажлын байранд сургалт хийх, хуулиа сурталчлах, хуулийн талаарх мэдлэгийг иргэдэд өгөх гээд маш олон төрлийн хариултыг өгсөн байна. Иргэд сүүлийн үед мэдээлэл маш их авч байгаа гэсэн боловч иргэдийн зарим хэсэгт мэдээлэл огт хүрэхгүй, мэдлэг, мэдээлэл муутай, боловсрол багатай, өөрийгөө хамгаалах, хаана хандахаа мэдэхгүй хүмүүс нэлээд хувийг эзэлж байгаа нь мэдлэггүй, өөрийн мэдлэгт эргэлзэж байгааг харуулж байна. ЖСХ болон ГБХ-ийн талаарх мэдлэг хангалтгүй байна гэж олон нийт үзэж байгаа нь судалгаанд хамрагдсан иргэдийн 68.1 хувь нь өөрийн мэдлэгийг дундаас доогуур үнэлсэнээс харагдаж байна. Мөн ЖСХ, ГБХ-ийн талаар сургуулийн хөтөлбөрт оруулах болон сургууль дээр нь сургалт маш сайн хийх, ажлын байранд ёс зүйн хичээл, сургалт явуулах нь зүйтэй гэж үзжээ. Түүнчлэн ямар ч арга зам байхгүй гэж хариулсан хүмүүс ч байна. Гэсэн хэдий ч, ЖСХ-ийн үндсэн шалтгаан болох жендэрийн тэгш бус байдал, эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг арилгахыг хэн ч санал болгоогүй байгааг тэмдэглэх нь зүйтэй. **ЖСХ, ГБХ-ээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд давтамжтай мэдээлэл хүргэх нь чухал байна.**
- Судалгаанд хамрагдсан иргэдийн 59.6 хувь нь дүүрэг, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ болон ТХБ-ны талаар ямар ч мэдээлэлгүй гэж хариулсан. Харин иргэдийн 35.0 хувь нь энэ талаар мэдээлэлтэй, 5.4 хувь нь орон нутгийнхаа НЦҮТ, ТХБ-ны талаар мэддэг бөгөөд очиж үйлчлүүлж байсан гэж хариулсан. **НЦҮТ, ТХБ-ны талаар мэдээлэлгүй олон хүмүүс энэ талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх хэрэгцээ байна гэж үзэж байгаа ч энэ нь тус төвүүдээр үйлчлүүлж буй хүмүүст аюул учруулахгүй байх ёстой. Тухайлбал, НЦҮТ болон ТХБ-ны бүтэн хаягийг бусдад мэдээлэхгүй байх шаардлагатай байдаг.**



## НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамж

НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдийн байдал, сэтгэл ханамжийг судлахын тулд ЖСХ болон ГБХ-д өртсөн мөн НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлж байсан иргэдээс нэмэлт асуултуудыг асуусан. Энэ 2 нөхцлийг хангасан нийт 196 иргэн байсан бөгөөд нэмэлт асуултад хариулахыг зөвшөөрсөн. Эдгээр иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал янз бүр байсан.

- НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэдээс тухайн төвөөр хэдэн удаа үйлчлүүлснийг тодруулахад иргэдийн 61.5 хувь нь анх удаа, 38.5 хувь нь 2, түүнээс олон удаа үйлчлүүлсэн байна. Мөн эмэгтэйчүүдийн 41.4 хувь нь давтан үйлчлүүлсэн байна. Эндээс харахад ЖСХ, ГБХ үйлдэгч нь нэг хохирогчийн эсрэг дахин давтан хүчирхийлэл үйлдэж байгааг харуулж байна. Мөн өндөр настай иргэд хүчирхийлэлд дахин давтан өртсөөр байна. Эдгээр үр дүнгээс 2 дүгнэлт гаргаж болохоор байна. Нэгдүгээрт, **залуу насны хүмүүсийн дунд НЦҮТ, ТХБ-аар нэг удаа үйлчлүүлсэн нь дийлэнх хувийг эзэлж байгаа хэдий ч тэд аль хэдийн хүчирхийлэлд өртсөн байгаа нь түгшүүр төрүүлж байна.** Энэ нь нас ахих тусам дахин давтан болон үргэлжлүүлэн хохирогч болох мөн НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлэх давтамж нэмэгдэх эрсдэлтэй байгааг харуулж байна. Хоёрдугаарт, ихэнх НЦҮТ, ТХБ нь сүүлийн 10 жилийн хугацаанд байгуулагдсан ба энэ нь өндөр настай иргэд зөвхөн энэ хугацаанд тус төвүүдээр үйлчлүүлсэн байх магадлалтайг харуулж байна. Иймээс **өндөр настны эсрэг ЖСХ, ГБХ-ийг тэдний хүүхдүүд нь үйлдэж байж болзошгүй юм.**
- НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд ямар нөхцөл, байдлаас үүдэн НЦҮТ болон ТХБ-нд ирснийг тодорхойлоход эдгээр иргэдийн 37.3 хувь нь гэр орондоо байх аргагүй болсон, 21.3 хувь нь хүчирхийлэлд өртөөд гэмтсэн, 10.7 хувь нь хүчирхийлэл үйлдэгчээс нуугдахаар ирсэн байна. Харин 30.7 хувь нь бусад шалтгаантай байна. Мөн НЦҮТ, ТХБ-нд ирсэн зорилгыг асуухад үйлчлүүлсэн иргэдийн 78.1 хувь нь хамгаалуулахаар ирсэн нь үндсэн шалтгаан болж байна. Нэмж хэлэхэд 18.3 хувь нь очих газар байгаагүй тул харин 3.6 хувь нь амьд үлдэхийн тулд тус газарт очсон байна. Эндээс харахад НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлэхээр ирсэн 25 хүн тутмын нэг нь амиа аврахаар иржээ. **Эндээс НЦҮТ, ТХБ-ны ач холбогдол болон хүчирхийлэлд өртөгчид амь насаа алдахаас урьдчилан сэргийлэхэд гүйцэтгэж буй үүрэг, оролцоо ямар их байгааг онцолж хэлэхээр байна.**
- НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлсэн иргэд тус газарт ирээд 4 төрлийн үйлчилгээ авсан бөгөөд ихэвчлэн (34.3 хувь) хамгаалуулсан байна. Мөн 27.2 хувь нь бусад төрлийн зөвлөгөө авсан, 14.8 хувь нь эрүүл мэндийн үйлчилгээ, 8.9 хувь нь хууль, эрх зүйн үйлчилгээ авсан. Гэсэн хэдий ч НЦҮТ, ТХБ-аар үйлчилүүлсэн иргэдийн 12.4 хувь нь хүссэн үйлчилгээгээ авч чадаагүй, 34.9 хувь нь заримыг нь авсан гэж хариулжээ.

- Судалгаанд хамрагдсан 17 НЦҮТ болон ТХБ-ны үйл ажиллагаанд үйлчлүүлсэн иргэд үйлчилгээ үзүүлэгчдийн хандлага, харилцаа, мэдлэг, туршлага, үйлчилгээний чанар, байрны тохижилт, нууцлал, аюулгүй байдал зэрэгт үнэлгээ өгсөн. Эдгээр 5 зүйлд судалгаанд хамрагдагчдын ихэнх нь “дундаас дээгүүр” оноо өгсөн (56.3-61.5 хувь) бол багахан (10.1-14.3 хувь) хэсэг нь “дундаас доогуур” үнэлгээ өгжээ. **Гэсэн хэдий ч ЖСХ-д өртсөн иргэдийг чанартай үйлчилгээгээр хангахын тулд төвүүдийн хүний нөөц, хүчин чадалд хөрөнгө оруулалт хийх ёстой юм.**
- НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлснээр иргэдийн амьдралд өөрчлөлт гэсэн байдлыг тодруулахад 56.2 хувь нь эерэг өөрчлөлт гарсан, 40.2 хувь нь ямар нэгэн өөрчлөлт гараагүй гэжээ. Харин 3.6 хувь нь улам дордсон гэж хариулсан байна. **Эдгээр үр дүнгүүд НЦҮТ, ТХБ нь зөвхөн хүчирхийлэлд өртсөн иргэдийг хамгаалахад биш тэдний амьдралд урт хугацаанд эерэгээр нөлөөлөхөд чухал ач холбогдолтой байгааг улам тодоор харуулж байна.**
- НЦҮТ-ийн талаарх мэдээллийг хаанаас, хэрхэн авсан тухай иргэдээс асуухад ихэнх (45.0 хувь) нь бусдаас ам дамжуулан сонссон бол 34.4 хувь нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон олон нийтэд зориулсан арга хэмжээнээс уг мэдээллийг авсан гэжээ. Мэдээлэл түгээхэд хөдөө, орон нутагт олон нийтийн арга хэмжээ нь ач холбогдолтой байгаа бол Улаанбаатар хотын иргэдийн хувьд интернэт, сошиал медиа нь чухал ач холбогдолтой байгаа нь харагдаж байна.

### **НЦҮТ, ТХБ-ны үнэлгээ**

Энэхүү үнэлгээг судалгаанд хамрагдсан 17 НЦҮТ болон ТХБ-ны хүрээнд хийсэн бөгөөд боловсруулсан асуултын дагуу, судлаачид төвүүдэд очиж, үнэлгээ хийсэн болно.

- Улсын хэмжээнд нийт 29 (Улаанбаатар хотод 9, аймагт 20) НЦҮТ, ТХБ байгуулагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан 17 төвөөр зөвхөн 2019 онд 2118 (1697 эмэгтэй, 421 эрэгтэй) хүн үйлчлүүлсэн байна. Сүүлийн 6 жилийн хугацаанд төвүүдээр үйлчлүүлэгчдийн тоо тогтмол өссөн бөгөөд 2019-өөс 2018 оны хооронд хамгийн өндөр (37.7 хувь) өсөлттэй байна.
- НЦҮТ, ТХБ-ны хүчин чадлыг үнэлэхэд 13 нь 4-12 ортой, хоёр нь 24-өөс дээш ортой, хоёр нь 2, түүнээс бага ортой байна. Нэмж хэлэхэд зөвхөн 7 төв нь хүүхдийн тусдаа өрөөтэй, 9 нь чөлөөт цагийн өрөөтэй, 14 нь тусдаа гал тогооны өрөөтэй байна. Зөвхөн 5 төв (Архангай, Дархан-Уул, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай) гал тогооны, хүүхдийн, чөлөөт цагийн тусдаа өрөөтэй байна.

- Мөн судалгаанд хамрагдсан төвүүдийн хүний нөөцийг харахад 11 нь 5, түүнээс цөөн ажиллагчтай байна. НЦҮТ болон ТХБ-нд шаардлагатай ажиллагчдын тоо нь тэдний үзүүлж буй үйлчилгээ болон үйлчилгээ авч буй иргэдийн дундаж тооноос хамаардаг. Гэвч хүчирхийлэлд өртөгчдийг олон төрлийн үйлчилгээгээр хангах, асрах зэрэг хангалттай (24/7) тооны ажилтантай байх ёстой. Эдгээр төв нь цөөн тооны ажиллагчтай, хангалттай цалинтай биш байгаа нь хүчирхийлэлд өртсөн иргэдэд хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээл учруулж болзошгүйг харуулж байна.
- Мөн үйл ажиллагаа явуулж буй НЦҮТ, ТХБ-нд очсон судлаачид 5 (байрны тохижилт, үйл ажиллагааны тогтвортой байдал, мэдээллийн бэлэн байдал, самбарын ашиглалт, байрны нууцлал, аюулгүй байдал) чиглэлд онцгой анхаарч өөрсдийн үнэлгээг гаргасан. Судалгаанд хамрагдсан нийт төвийн дийлэнх нь “дунджаас дээгүүр” үнэлгээ авсан бөгөөд хамгийн өндөр (94.1 хувь) үнэлгээг үйл ажиллагааны тогтвортой байдал, байрны тохижилт (82.4 хувь)-д өгжээ. Нөгөө талаар мэдээллийн хүртээмжтэй байдалд “дунджаас доогуур” үнэлгээ өгсөн нь хамгийн бага үнэлгээ байлаа.
- Судлаачид мөн төвүүдийн 7 үйлчилгээ (аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлэг болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээ)-нд үнэлгээ өгсөн. Судлаачид хамгийн өндөр үнэлгээг сэтгэл зүйн үйлчилгээ, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээ болон холбон зуучлах үйлчилгээнд өгсөн байна. Нөгөө талаар хоёр ч үйлчилгээнд “дунджаас доогуур” оноо өгсөн нь Хан-Уул дүүргийн ГБХЗХХ-ийн харьяа НЦҮТ бөгөөд аюулгүй байдлын хамгаалалтын хувьд 1, эмнэлгийн тусламж үйлчилгээний хувьд 4 гэж үнэлжээ.

### ***Сургамж болон НЦҮТ, ТХБ-ны үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж***

- НЦҮТ болон ТХБ-ны хүчин чадал нь тэдгээр төвүүдийг харьяалж ажилладаг байгууллага, агентлагын удирдлагаас гадна эдгээр үйлчилгээний төвийн төсвийг улсын болон орон нутгийн түвшинд хуваарилдаг улс төрийн шийдвэр гаргагчдаас инхээхэн хамаарч байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй байна. Шийдвэр гаргагчид ЖСХ ба ГБХ-ийг онцгойлон авч үзсэн нөхцөлд л НЦҮТ болон ТХБ-ууд нь хүний нөөц болон тохижилт хоёрын хоёуланд нь зориулагдсан хангалттай төсвийн тогтвортой хөрөнгө оруулалтад үндэслэн үйл ажиллагаагаа тогтвортойгоор явуулах, өргөтгөх боломжтой болох юм. Иймээс НЦҮТ, ТХБ байр нь ЖСХ, ГБХ-д өртсөн хүмүүст чанартай үйлчилгээг үргэлжлүүлэн хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгааг болон цаашид зайлшгүй хэрэгцээ байгааг эдгээр шийдвэр гаргагчдад сурталчлан таниулах нь чухал юм.

- НЦҮТ, ТХБ-ны ажиллагчид тухайн төвийн хүчин чадал, үйлчилгээнд үнэлгээ өгч ажилласан судлаачдад дараах хүндрэл бэрхшээл болон зөвлөмжийг дурдсан байна.
  - ◆ Төсвийн хүрэлцээгүй, тогтвортой бус хуваарилалт нь төвүүдийн тогтвортой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөс гадна чанартай үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээл учруулж байна.
- **НЦҮТ, ТХБ-ны 17 нэгжийн анхдагч мэдээлэл буюу бүртгэл маш сул байгаа нь цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэг нь бүртгэлийг боловсронгуй болгох, нэгдсэн мэдээллийн эх үүсвэрийг бий болгох шаардлагатай байгааг харуулж байна.**
  - ◆ Бүх НЦҮТ, ТХБ-ны үйл ажиллагаанд нийцэхүйд бүртгэл, мэдээллийн нэгдсэн загвар, системийг боловсруулж ашиглахаас гадна улсын хэмжээнд ЖСХ, ГБХ-ийн хүчирхийллийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.
  - ◆ Хүчирхийлэлд өртөөд үйлчлүүлж буй иргэдийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд зарим төвд хүүхдийн өрөө, чөлөөт цагаа өнгөрүүлэх өрөөг бий болгох, гадна талбайг тохируулах (номын сан, кабелийн телевиз) шаардлагатай байна. Мөн үйлчлүүлэгчид болон төвийн ажиллагчдын аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын нөхцөл байдлыг сайжруулах зайлшгүй шаардлага байсаар байна.
  - ◆ Үйлчилгээгээ илүү сайн үзүүлэхийн тулд ажиллагчдыг байнга сургаж, сургалтад хамруулж байх хэрэгцээ байсаар байна. Нэмж хэлэхэд хүчирхийлэлд өртөөд сэтгэцэд нь нөлөөлсөн хүмүүстэй ажиллаж буй ажиллагчдын сэтгэцийн эрүүл мэндэд анхаарал хандуулах хэрэгтэй. Учир нь энэ нь үйлчилгээ авч буй иргэдэд нөлөөлөх магадлалтай бөгөөд үйлчлүүлэгчид болон ажиллагчдад аль алинд нь тустайг анхаарах хэрэгтэй.
  - ◆ Мэргэжлийн сэтгэл судлаач, сэтгэл зүйчдийн эрэлт, хэрэгцээ их байна. Ялангуяа аймгуудын НЦҮТ, ТХБ-нд эдгээр мэргэжилтнүүд маш их хэрэгцээтэй байна. НЦҮТ, ТХБ-аар үйлчлүүлээд гарсны дараа иргэдэд өдөр тутмын хэвийн амьдралдаа эргэн орох, өөрийгөө хамгаалахад нь туслах зорилгоор мэдээлэл өгөхийн тулд видео бичлэг, шторк зэргийг бэлтгэж хангах шаардлага байна.

## ХАВСРАЛТ 1. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НЭР

### Судалгааг зохион байгуулагчид, оролцогчид:

А.Ариунзаяа	ҮСХ-ны дарга
А.Амарбал	ҮСХ-ны ХАНСГ-ын дарга
Б.Оюун	НҮБ-ын Хүн амын сан, Жендэрийн хөтөлбөрийн зохицуулагч
Насташа Франческа	НҮБ-ын Хүн амын сан, ЖСХ-тэй тэмцэх нь төслийн ажилтан
Л.Билгүүн	НҮБ-ын Хүн амын сан, ЖСХ-тэй тэмцэх нь төслийн ажилтан
Н.Должинсүрэн	ҮСХ-ны ХАНСГ-ын НСА-ны ахлах статистикч
Л.Зулцэцэг	Судалгааны ажилтан
Г.Уранбайгаль	Судалгааны ажилтан
Д.Ганчимэг	Судалгааны ажилтан
Г.Эрдэнэ	Судалгааны ажилтан

### Судалгааны мэдээлэл цуглуулагч, шивэгч нар:

Аймаг:	Судлаачид	Улаанбаатар:
Архангай:	Б.Аззаяа	М.Азжаргал
Баян-Өлгий:	Б.Жанар	Х.Анударь
Баянхонгор:	Т.Оюунгэрэл	Б.Буян-Оргил
Булган:	М.Даариймаа	Э.Долгорсүрэн
Говь-Алтай:	Б.Батцэрэн	Б.Мишээл
Говьсүмбэр:	Н.Сэрээтэр	О.Мөнгөнзул
Дархан-Уул:	Д.Батжаргал	Д.Нүрмаа
Дорноговь:	Д.Мөнхболор	Б.Отгончимэг
Дорнод:	Э.Болдхүрэл	А.Оюунболд
Дундговь:	Г.Баясгалан	Э.Ундармаа
Завхан:	Б.Сэвжидмаа	Б.Хишигбайгаль
Орхон:	М.Лхагважаргал	Б.Хишигтогтох
Өвөрхангай:	О.Бямбадулам	Э.Цэрэнбат
Өмнөговь:	М.Баасанжав	Э.Энхболд
Сүхбаатар:	Б.Гэрэлмаа	
Сэлэнгэ:	П.Энхчимэг	
Төв:	С.Батбаяр	
Увс:	Г.Цэдэнбал	
Ховд:	Т.Анхбаяр	
Хөвсгөл:	О.Бадамгарав	
Хэнтий:	Г.Пэрэнлэйдорж	

## ХАВСРАЛТ 2. АСУУЛГЫН ХУУДАС 1

Олон нийтийн мэдлэг, ойлголт, хандлагад гарсан өөрчлөлт - 2019

Олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд мэдлэг, ойлголт, хандлагад гарсан өөрчлөлт

N1. Аймаг/дүүргийн нэр, код

N2. Асуулгын дугаар

N3. Судлаачийн нэр, код

N4. Судалгааны үр дүн

(Бүрэн - 1, Дутуу - 2, Татгалсан - 3)

N5. Хариулагчийн амьдарч буй байршил (Нийслэл - 1, Аймгийн төв - 2, Сумын төв - 3, Хөдөө - 4)

Судалгаа авсан сар/өдөр, эхэлсэн цаг, минут

\_\_\_ / \_\_\_ : \_\_\_

№	АСУУЛТ	ХАРИУЛТ	АЛХАМ
G1	Та хэдэн настай вэ?	Бүтэн нас	
G2	Таны хүйс	Эрэгтэй 1 Эмэгтэй 2	
G3	Таны эзэмшсэн боловсролын дээд түвшин юу вэ?	Боловсролгүй 1 Бага 2 Суурь 3 Бүрэн дунд 4 Техникийн болон мэргэжлийн 5 Тусгай мэргэжлийн дунд 6 Дипломын болон бакалаврын дээд 7 Магистр/Доктор 8 Мэдэхгүй/санахгүй байна 9	
G4	Та сүүлийн 7 хоногт ямар нэгэн ажил эрхэлсэн үү?	Тийм 1 Үгүй 2	G5
	Таны сүүлийн 7 хоногт эрхэлсэн үндсэн ажил дараах ангиллын алинд нь хамаарах вэ?	Цалинтай ажил 1 Цалин хөлсгүй ажил 2 Хувиараа хөдөлмөр эрхэлдэг: 3 Мал аж ахуй 4 Газар тариалан 5 Бусад 6	M1
G5	Сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй үндсэн шалтгаанаа хэлнэ үү?	Өвчтэй 1 Жирэмсэн 2 Бусдыг асарсан 3 Амарч байсан 4 Түр зогсолт 5 Улирлын чанартай ажил 6 Ажил олдоогүй 7 Бусад 8	
G6	Та сүүлийн 7 хоногт ажил хайсан уу?	Тийм 1 Үгүй 2	G8
G7	Та ямар аргаар ажил хайсан бэ?	Хөдөлмөрийн хэлтэс, Хөдөлмөрийн биржид хандсан 1 Найз, нөхөд, хамаатан садангаасаа тусламж хүссэн 2 Хэвлэл мэдээллийн зарын дагуу хайсан 3 Өөрөө сонинд зарлал өгсөн 4 Ажил олгогч нарт өргөдөл өгч хандсан 5 Бусад 6	M1



	АСУУЛТ	ХАРИУЛТ	АЛХАМ
<b>G8</b>	Сүүлийн 7 хоногт ажил хайгаагүй шалтгаанаа хэлнэ үү?	Оюутан/сурагч	1
		Өндөр настай	2
		Гэрийн ажилтай, хүүхэд асардаг	3
		Ажил хүлээж байгаа	4
		Тохирох ажил олдохгүй байгаа	5
		Өвчтэй хүн асардаг	6
		Хөгжлийн бэрхшээлтэй	7
		Бусад	8
<b>G9</b>	Та хөдөлмөрийн хэлтэс/Хөдөлмөрийн биржид бүртгэлтэй юу?	Тийм	1
		Үгүй	2
<b>Жендэрт суурилсан хүчирхийллийн талаар хэдэн асуулт асууя.</b>			
<b>M1</b>	Жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн талаар Та өөрийгөө хэр мэдлэгтэй гэж дүгнэх вэ?	Огт	Маш
		мэдэхгүй	Дунд сайн
		1 2 3 4 5 6 7 8 9	
<b>M2</b>	<b>Юуг ойлгодог талаар тайлбарлаж өгнө. Дараа нь асууж эхэлнэ.</b> ЖСХ болон гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгаан юу вэ? Эрэмбэлээд бичнэ.	1	<input type="text"/>
		2	<input type="text"/>
		3	<input type="text"/>
		4	<input type="text"/>
		Үнэхээр мэдэх юм алга	6
<b>M3</b>	ЖСХ болон гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлдөг хүчин зүйл юу вэ?	1	<input type="text"/>
		2	<input type="text"/>
		Үнэхээр мэдэх юм алга	6
<b>M4</b>	ЖСХ болон гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил мөн үү?	Мэдээж мөн	1
		Биш	2
		Сайн мэдэхгүй байна	8
<b>M5</b>	ЖСХ болон ГБХ нь гэмт хэрэг мөн үү?	Мэдээж мөн	1
		Биш	2
		Сайн мэдэхгүй байна	8
<b>M6</b>	Хүний эрхийн комисст гомдол гаргаж хандаж байсан уу?	Тийм	1
		Үгүй	2
		Гаргадаг гэж мэдэхгүй	8
<b>M7</b>	Хамтарсан баг, төрийн бус байгууллагын зохион байгуулсан олон нийтийн болон дэмжих бүлэгт орж байсан уу?	Тийм	1
		Үгүй	2
		Гаргадаг гэж мэдэхгүй	8
<b>M8</b>	ЖСХ болон ГБХ –ээс урьдчилан сэргийлэх арга замын талаарх таны санал бодол юу вэ?	1	<input type="text"/>
		2	<input type="text"/>
		3	<input type="text"/>

АСУУЛТ	ХАРИУЛТ	АЛХАМ
<b>M9</b> ЖСХ болон ГБХ-ийн гол буруутан эмэгтэйчүүд өөрсдөө байдаг гэдэгтэй Та санал нийлэх үү? Тийм бол Яагаад? Үгүй бол яагаад?	Тийм <span style="float: right;">1</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
	Үгүй <span style="float: right;">2</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
<b>M10</b> Сайн эхнэр санал нийлэхгүй байсан ч нөхрийнхөө саналыг дэмжих ёстой гэдэгтэй Та санал нийлэх үү? Яагаад	Санал нийлж байна <span style="float: right;">1</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
	Санал нийлэхгүй <span style="float: right;">2</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
<b>M11</b> Эхнэр буруу зүйл хийсэн байвал нөхөр нь зодож, зэмлэж, шийтгэж болно гэдэгтэй Та санал нийлэх үү? Яагаад	Санал нийлж байна <span style="float: right;">1</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
	Санал нийлэхгүй <span style="float: right;">2</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
<b>M12</b> Хүчирхийллийг тэвчсэнээр гэр бүлээ аварч хүүхдүүдээ өнчрүүлэхгүй гэдэгтэй Та санал нийлэх үү? Яагаад	Санал нийлж байна <span style="float: right;">1</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
	Санал нийлэхгүй <span style="float: right;">2</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
<b>M13</b> Зарим тохиолдолд хүчирхийллийг зөвтгөх үндэслэл байж болно гэдэгтэй Та санал нийлэх үү? Яагаад	Санал нийлж байна <span style="float: right;">1</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
	Санал нийлэхгүй <span style="float: right;">2</span> яагаад <input type="checkbox"/> <input type="checkbox"/>	
<b>M14</b> ЖСХ, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хэн байж болох вэ?	Хүүхэд <span style="float: right;">A</span>	
	Эмэгтэй хүн <span style="float: right;">B</span>	
	Эрэгтэй хүн <span style="float: right;">C</span>	
	Ээж, аав <span style="float: right;">D</span>	
	Хүчирхийлэл үйлдэгчээс бусад гишүүд <span style="float: right;">E</span>	
<b>M15</b> ЖСХ болон ГБХ үйлдэгч хэн байж болох вэ?	1 <input type="checkbox"/>	
	2 <input type="checkbox"/>	
	3 <input type="checkbox"/>	



	АСУУЛТ	ХАРИУЛТ	АЛХАМ
<b>M16</b>	Та ЖСХ болон ГБХ-т өртөж байсан уу ? Хэрхэн мэдэх вэ?	Үгүй	1
		Тийм	2
			<input type="checkbox"/>
<b>M17</b>	ЖСХ болон ГБХ-ийн шинж тэмдгүүд, хүчирхийлэл үйлдэгчийн түгээмэл шинж, хэрэглэдэг арга замуудын талаар Та юу мэдэх вэ?		<input type="checkbox"/>
			<input type="checkbox"/>
<b>M18</b>	Таны оршин суугаа аймаг/дүүрэгт Нэг цэгийн үйлчилгээний төв байр байдаг уу? Та мэдэх үү?	Тийм, мэднэ	1
		Тийм, очиж байсан	2
		Мэдэхгүй	3
<b>Q1</b>	Нэмэлт судалгааны асуулгад сонгогдсон эсэх	Тийм	1
		Үгүй	2 → <b>Q14</b>
<b>Q2</b>	Нэмэлтээр авах судалгааны асуулгыг зөвшөөрсөн эсэх	Зөвшөөрсөн	1
		Зөвшөөрөөгүй	2 → <b>Q14</b>
<b>Q3</b>	Нэг цэгийн үйлчилгээний төвийн (НЦҮТ) талаарх мэдээллийг анх хаанаас авсан бэ?	Найз, нөхөд	1
		Аав, ээж	2
		Ах, дүү	3
		Ажлынхан, бусад танил	4
		Телевиз	5
		Интернэт	6
		Радио, FM	7
		Зурагт хуудас	8
		Олон нийтэд зориулсан арга хэмжээ	9
		Бусад	10
<b>Q4</b>	Та “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр хэд дэх удаагаа үйлчлүүлж байна вэ?	Анх удаа	1
		2 удаа	2
		3 удаа	3
		4 өөс дээш	4
<b>Q5</b>	НЦҮТ-д ямар зорилгоор ирсэн /өөрөөр хэлбэл яг юу хүсч ирсэн бэ?	Хамгаалуулахыг	1
		Очих газар байгаагүй	2
		Амьд үлдэхийг	3
<b>Q6</b>	НЦҮТ-д ямар нөхцөлд ирсэн бэ? Өөрөөр хэлбэл яагаад ирсэн бэ? Жишээ нь - Үнэхээр өөр очих газаргүй болоод ирсэн, - Ямар нэгэн гэмтэл авсан яаралтай тусламж хэрэгтэй байсан - Нуугдах шаардлагатай, зугтаж ирсэн ч гэх юмуу гм	Гэр орондоо байх аргагүй болсон	1
		Хүчирхийлэлд өртөөд гэмтсэн	2
		Нуугдах	3
		Бусад бичих	4
<b>Q7</b>	НЦҮТ-д ирээд ямар үйлчилгээ авсан бэ?	Хамгаалагдсан	1
		Эрүүл мэндийн үйлчилгээ	2
		Зөвлөгөө	3
		Хууль эрх зүйн	4
		Бусад бичих	5

	АСУУЛТ	ХАРИУЛТ	АЛХАМ
<b>Q8</b>	НЦҮТ-д ирээд авахыг хүссэн ч авч чадаагүй үйлчилгээ бий юу? Авч чадаагүй үйлчилгээ байгаа юу? Авч чадаагүй үйлчилгээг бичих	Бүрэн авсан	1
		Заримийг нь авсан	2
		Огт чадаагүй	3
			<input type="checkbox"/>
<b>Q9A</b>	НЦҮТ-ийн үйлчилгээг ерөнхийд нь дүгнээд үнэлгээ өгвөл  1. Үйлчилгээ үзүүлэгчдийн хандлага, харилцаа 2. Мэдлэг, туршлага 3. Үйлчилгээний чанар 4. Байрны тохижилт 5. Нууцлал, аюулгүй байдал	Маш муу	Маш сайн
		1 2 3 4 5 6 7 8 9	1 2 3 4 5 6 7 8 9
		1 2 3 4 5 6 7 8 9	1 2 3 4 5 6 7 8 9
		1 2 3 4 5 6 7 8 9	1 2 3 4 5 6 7 8 9
		1 2 3 4 5 6 7 8 9	1 2 3 4 5 6 7 8 9
		1 2 3 4 5 6 7 8 9	1 2 3 4 5 6 7 8 9
<b>Q9B</b>	Таны бодлоор үйлчилгээгээ бүрэн үзүүлсэн үү?	Тийм	1
		Үгүй	2
<b>Q10</b>	НЦҮТ-д үзүүлж байгаа үйлчилгээний давуу болон сул талууд	Давуу тал нь илүү	1
		Сул тал нь илүү	2
		Мэдэхгүй	3
<b>Q11</b>	НЦҮТ-ийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх талаарх санал		<input type="checkbox"/>
<b>Q12</b>	НЦҮТ-өөр үйлчүүлснээр таны амьдралд ямар нэг өөрчлөлт гарсан уу?	Эерэг өөрчлөлт	1
		Өөрчлөлт гараагүй	2
		Улам дордсон	3
<b>Q13</b>	Гарсан өөрчлөлтийг нэг үгээр илэрхийлбэл		<input type="checkbox"/>
<b>Q14</b>	Танай өрх наад захын хэрэгцээгээ хангаж чаддаг уу?	Тийм	1
		Үгүй	2
		Мэдэхгүй	8
<b>Q15</b>	Ирэх жилүүдэд амьдрал улам сайхан болно гэдэгтэй Та санал нийлүүлэх үү?	Тийм, санал нийлж байна	1
		Үгүй, санал нийлэхгүй	2
		Хэвээрээ үргэлжлэх байх	3
		Мэдэхгүй байна	4
<b>Q16</b>	Энэ үйл ажиллагааг Та харсан уу? Хэвлэсэн хуудас харуулж асууна.	Телевиз	1
		Интернэт	2
		Радио, FM	3
		Зурагт хуудас	4
		Олон нийтэд зориулсан арга хэмжээ	5
		Бусад	6
		Огт хараагүй	7
	Ярилцлага дууссан цаг, минут		:

## АСУУЛГЫН ХУУДАС 2

Олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд мэдлэг, ойлголт, хандлагад гарсан өөрчлөлт

### Нэг цэгийн үйлчилгээний төвийн ерөнхий үнэлгээ хийх асуулга

Н1. Аймаг/дүүргийн нэр, код

Н2. Үнэлгээ хийж буй төвийн хаяг

АСУУЛТ	ХАРИУЛТ																												
<b>A1</b> Нэг цэгийн үйлчилгээний төвийн байгуулагдсан он	он <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/>																												
<b>A2</b> НЦҮТ-өөр үйлчилүүлсэн хүний тоо	<table border="1"> <thead> <tr> <th></th> <th>Нийт</th> <th>Эрэгтэй</th> <th>Эмэгтэй</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>A. 2019 он</td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> </tr> <tr> <td>B. 2018 он</td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> </tr> <tr> <td>C. 2017 он</td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> </tr> <tr> <td>D. 2016 он</td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> </tr> <tr> <td>E. 2014 он</td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> </tr> <tr> <td>F. 2013 он</td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> </tr> </tbody> </table>		Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	A. 2019 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	B. 2018 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	C. 2017 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	D. 2016 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	E. 2014 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>	F. 2013 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй																										
A. 2019 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>																										
B. 2018 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>																										
C. 2017 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>																										
D. 2016 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>																										
E. 2014 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>																										
F. 2013 он	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>																										
<b>A3</b> Нийт ажиллагчдын тоо (2019 оны байдлаар)	<table border="1"> <thead> <tr> <th>Нийт</th> <th>Эрэгтэй</th> <th>Эмэгтэй</th> </tr> </thead> <tbody> <tr> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> <td><input type="text"/></td> </tr> </tbody> </table>	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>																						
Нийт	Эрэгтэй	Эмэгтэй																											
<input type="text"/>	<input type="text"/>	<input type="text"/>																											
<b>A4</b> Нэг цэгийн үйлчилгээний төвийн хүчин чадал	<p>Хүлээн авах нийт хүний тоо <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/></p> <p>1 Байрны орны тоо <input type="text"/> <input type="text"/></p> <p>2 Гал тогооны өрөөтэй эсэх (Тийм 1, Үгүй 2) <input type="checkbox"/></p> <p>3 Хүүхдийн өрөөтэй эсэх (Тийм 1, Үгүй 2) <input type="checkbox"/></p> <p>4 Чөлөөт цагийн өрөөтэй эсэх (Тийм 1, Үгүй 2) <input type="checkbox"/></p> <p>5 Хүүхдэд зориулсан өрөөтэй эсэх (Тийм 1, Үгүй 2) <input type="checkbox"/></p> <p>6 Сууцны талбай <math>m^2</math> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/></p> <p>7 Гадна нийт талбай <math>m^2</math> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/></p> <p>8 Байр нь өөрийн өмчийн эсэх (Тийм 1, Үгүй 2) <input type="checkbox"/></p>																												
<b>A5</b> НЦҮТ-д 2020 онд яаралтай хийх тулгамдсан үйл ажиллагаа байгаа эсэх	<p>Тийм ..... 1</p> <p>Үгүй ..... 2</p>																												

АСУУЛТ		ХАРИУЛТ																										
<b>S1</b>	<b>Судлаачийн дүгнэлт</b>	<b>Маш муу</b>									<b>Дунд</b>									<b>Маш сайн</b>								
	Тохижилтын хувьд	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	1 НЦҮТ-ийн байрны тохижилт	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	2 Үйл ажиллагааны тогтвортой байдал	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	3 Мэдээлэл, сурталчилгааны тарааж өгөх материал	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	4 Байранд байгаа мэдээлэл, сурталчилгааны самбарын ашиглалт баяжуулалт	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	5 Байрны нууц байдал болон хамгаалалт/хамгаалалтын систем	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	Үйлчилгээний хувьд	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	1 Аюулгүй байдлын хамгаалалт	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	3 Сэтгэл зүйн үйлчилгээ	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	4 Нийгмийн халамжийн үйлчилгээ	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	5 Хүүхэд хамгааллын үйлчилгээ	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	6 Эрх зүйн туслалцаа	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	7 Холбон зуучлах үйлчилгээ	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9	1	2	3	4	5	6	7	8	9
	<b>S2</b> НЦҮТ-д хийх нэн шаардлагатай үйл ажиллагаа юу вэ? Ангилаад дараалуулан бичнэ үү?	1 _____ 2 _____ 3 _____ 4 _____ 5 _____																										

Судалгаа авсан сар/өдөр

/

Эхэлсэн цаг, минут

:

Ярилцлага дууссан цаг, минут

:

-----oOo-----





